Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ /ХҮРЭЭГҮЙ БОЛ ТАЙЛБАР/	ХУВЬ
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт 1.1 Иргэдэд зориулсан спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.3/		-	Ажлын явц, хувь	-	Спортын цогцолборын зураг төсөл хийлгэнэ.	Газрын асуудал шийдэгдсэн. Зураг төсөв хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Зураг төсөв хийгдэж байна.	90%
1	1.1.1 Спортын цогцолборын барилгын зураг төсөл, төсвийг хийлгэн, барилга угсралтад шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар уламжилна.	200.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	-	Спортын цогцолборын зураг төсвийг хийлгэн, дээд шатны байгууллагад санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр санал уламжилсан байна.	Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Яармагийн урд дэнж, Нүхтийн замын баруун талд нийслэлийн Засаг даргын 2020 оны А/891 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт "Спорт цогцолбор"-ын зориулалтаар 2.5 га газар олгогдсон. Тус газарт Хот байгуулалт, хөгжлийн газраар 2021 оны МЗХ2021/18-001 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулж,	90%

						зураг төсвийг хийлгэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Зураг төсөв хийгдэж байна.	
Зорилт 1.2 Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. /ЗГҮАХ 2.3.9.2/		-	Ажлын явц, хувь	-	3-аас доошгүй цэцэрлэгийн барилгыг эхлүүлнэ.	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 цэцэрлэг барихаас 2 цэцэрлэгийн гэрээ байгуулагдсан. 1 цэцэрлэг тендерийн шатанд байна.	100%
2	1.2.1 Шинээр 3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	3,000.0 /ДТХО/	Барилгын ажлыг эхлүүлсэн цэцэрлэгийн тоо	-	3-аас доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр 21-р хороонд 280 ортой цэцэрлэг, 4 дүгээр хороонд 12-р цэцэрлэг 280 ортой өргөтгөлийн барилга, 6 дугаар хороонд 189 дүгээр цэцэрлэгийн 200 ортой өргөтгөл, 2 дугаар хороонд 150 ортой 65 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн ажил бүрэн дуусаж, Улсын комисс ажилласан. Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй дараах ажлууд байна. Үүнд: - 3 дугаар хороо, 240 ор бүхий 4-р цэцэрлэгийн барилга угсралтын ажил хийгдсэн. /Ажлын явц 95 хувь/ - 5 дугаар хороо, 150 ор бүхий 71-р цэцэрлэгийн барилгын карказ угсарч, дүүргэлтийн ажил хийгдсэн. /Ажлын явц 60%, - 9 дүгээр хороо 240 ортой 134-р цэцэрлэгийн барилгын карказ угсралт, дүүргэлтийн ажил хийгдсэн. /Ажлын явц 70 хувь/, - 300 ор бүхий "Цэцэрлэгийн барилга худалдан авах ажлын тендер зарлагдсан, 2021 оны 12 дугаар сарын 22-нд нээлт хийнэ. - 4 дүгээр хороо, Ханбогд хотхонд 200 ор бүхий цэцэрлэг худалдан авах ажлын тендер зарлагдсан, 2021 оны 12 дугаар сарын 22-нд нээлт хийнэ.	100%

						Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15 дугаар хорооны цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хуучин бага сургуулийн барилгыг цэцэрлэгийн барилга болгон засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, гэрээ байгуулагдах шатанд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 145 дугаар цэцэрлэгийн 100 ортой өргөтгөл, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр баригдах 72 дугаар цэцэрлэгийн 150 ортой өргөтгөлийн барилга худалдан авах ажиллагааны шатанд байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 4-р хороонд баригдах 200 ор бүхий цэцэрлэгийн карказ угсралтын ажил хийгдэж байна. 15-р хороонд баригдах 200 ортой цэцэрлэгийн газар шорооны ажил хийгдэж байна. 16 дугаар хороонд баригдах 200 ортой цэцэрлэгийн тендер 2 дахь удаа 2021.11.16-нд зарлагдсан. 2021.12.16-нд нээлт хийнэ.	
Зорилт 1.3 Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.7.11/		-	Ажлын явц, хувь	-	25% /3-аас доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна./	Дүүргийн төсөв болон дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 худгийн барилга ажил хүлээлцэх шатанд, 6 худгийн барилга гэрээ байгуулагдсан, хэрэгжих шатанд байна.	90%
3	1.3.1 Гэр хорооллын шаардлагатай байршлуудад 3-аас доошгүй ундны усны худгийг ашиглалтад оруулна.	240.0 /ДТХО/, 60.0 /ДОНХС	Ашиглалтад орсон худгийн тоо	-	3-аас доошгүй байршилд гүний худаг ашиглалтад оруулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд, он дамжин хэрэгжиж буй 12, 13 дугаар хороонд гүний худаг байгуулах ажлыг “Грандхолдинг” ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд хүлээлцэх шатанд байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд 9, 11, 12, 13, 14 дүгээр хороодод 6 байршилд баригдах гүний худгийн ажлыг гүйцэтгүүлэхээр	90%

						“Топдриллинг” ХХК-тай гэрээ байгуулагдсан. Газар шорооны ажил хийгдэж байгаа бөгөөд ажил 2022 онд үргэлжлэн хийгдэнэ.	
Зорилт 1.4 Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно. /ЗГҮАХ 3.7.12/		-	Ажлын явц, хувь	-	25% /2 байршилд үерийн ус зайлуулах шугам татсан байна./	Дүүргийн 5, 9, 17 дугаар хороонд 3 байршилд ус зайлуулах сувгийн ажил хийгдсэн.	100%
4	1.4.1 Дүүргийн 9 дүгээр хороонд тохижилт, үерийн хамгаалалт хийх ажлыг дуусган, ашиглалтад оруулж 6,7 дугаар хороонд голын гадаргын ус зайлуулах шугам татах ажлыг хийнэ.	85.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	Гэрээ байгуулагдсан	Ажлуудыг дуусган, ашиглалтад оруулсан байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17 дугаар хороонд Сэргээн засах клиник сувиллын зүүн урд талд борооны ус ихээр тогтдог байршилд үерийн ус зайлуулах суваг байгуулсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд 114 дүгээр сургуулийн зүүн талд 40 метр урттай үерийн ус зайлуулах суваг байгуулсан. 6, 7 дугаар хорооны голын засмал зам дагуу ус зайлуулах шугам татах ажлын гэрээ байгуулагдаж, бараа материал татан авалт хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа Яармаг орчмын бохирын шугамын ажлаас шалтгаалан хэрэгжихгүй болсон. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5-р хороо “Яармаг” худалдааны төвийн уулзвараас хойших 0.8 км авто зам дагуу борооны ус зайлуулах суваг хийгдсэн. Мөн үерийн болон борооны усанд автдаг байршлуудын судалгааг гаргаж, Хот байгуулалт, хөгжлийн газраас 5, 8, 9, 10, 16 дугаар хороодод шаардлагатай байршлуудад үерийн далан сувгийн зургийн ажлын даалгавар гаргуулахаар хүсэлт хүргүүлснээс 9, 10, 16 дугаар хороонд даалгавар батлагдсан. Тус ажлуудын зураг төсвийг “Гидродизайн	100%

						инженеринг” ХХК-аар гүйцэтгүүлж байна.	
Зорилт 1.5 Нийтийн эзэмшлийн зам талбайн камержуулалтыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 4.3.2/		-	Ажлын явц, хувь	-	50% /250-аас доошгүй байршилд камержуулсан байна./	Камержуулалтын ажлуудын байршлын судалгааг хийж, техникийн нөхцөл, техникийн даалгаврыг батлуулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. 117 ширхэг камер суурилуулахад шаардлагатай шилэн кабель татсан. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ерөнхий боловсролын 15, 18, 32, 52, 60, 75, 115, 118 зэрэг 8 сургуулийн орчимд 32 ширхэг камер шинээр суурилуулсан.	70%
5	1.5.1 Дүүргийн 1-11, 13-21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 250-аас доошгүй камер суурилуулж, хуучирч муудсан камеруудыг сэргээн засварлана.	1,319.9 /ДОНХС/	Ажлын явц, хувь	-	Нийтийн эзэмшлийн талбайд 250-аас доошгүй камер суурилуулна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжиж буй камержуулалтын ажлын зураг төсөв хийгдэж байна. Нийт 117 ширхэг камер суурилуулахад шаардлагатай шилэн кабелийг татсан. 2022 онд бүрэн хэрэгжиж дуусна.Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ерөнхий боловсролын 15, 18, 32, 52, 60, 75, 115, 118 зэрэг 8 сургуулийн орчимд 32 ширхэг камер шинээр суурилуулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжих 591.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Камержуулалт”-ын ажил худалдан авах ажиллагааны шатанд байна.	70%
Зорилт 1.6 Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. /ЗГҮАХ6.1.6/		-	Ажлын явц, хувь	-	50% /Хатуу хучилттай авто замыг байгуулсан байна./	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5, 16, 21-р хороодод 3.2 км хатуу хучилттай авто зам тавих ажил 80%-тай хийгдэж, зорчих хэсгийг нээсэн. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4, 10,	100%

						14 дүгээр хороонд 4.6 км авто зам ашиглалтад орсон.	
6	1.6.1 Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хэсгийг сайжруулах зорилгоор 4 км-ээс доошгүй хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна.	3,305.4 /ДТХО/, НТХО	Ашиглалтад орсон хатуу хучилттай авто зам, км	Ажлын явц 20 хувьтай	4 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна.	Дүүргийн 5-р хороо “Яармаг” худалдааны төвийн уулзвараас хойших 0.8 км авто зам, 21-р хорооны Иргэний нисэхийн ерөнхий газраас Буянт-Ухаа 2 хороолол хүртэлх 0,9 км авто, 16-р хороо Баруун сонсголонгийн гудамжнаас Тайнь 7-р гудамж дагуу Наадамчдын зам хүртэл 1,4 км авто замын асфальт бетон хучилт, борооны ус зайлуулах шугам, хэвтээ тэмдэглэгээний ажлууд хийгдэж, авто замын зорчих хэсэг бүрэн дууссан. Гэрэлтүүлэг, явган хүний замын ажил хийгдэж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4 дүгээр хороо, Нийслэлийн төр захиргааны байгууллагуудыг Хан-Уул дүүрэг, Яармаг шинэ дэд төвд шилжүүлэн байршуулах болсонтой холбогдуулан ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан авто зам /1.7 км/ -ыг ашиглалтад оруулсан. Мөн Наадамчдын замаас "АГАПЕ" эмнэлгийн баруун тал гэр хороолол дундуур Буянт-Ухаа цогцолбор сургууль хүртэл явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий 1км авто зам тавих ажил хийгдэж дууссан. Улсын төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Өлзийт хороолол чиглэлийн авто зам дахь “МТ” шатахуун түгээх станцын уулзвараас 14 дүгээр хорооны байр, 165 дугаар цэцэрлэг хүртэлх хатуу хучилттай авто зам хүртэл 2.6 км 2 урсгал, 2 эгнээ бүхий авто зам, дугуйн зам, явган хүний зам, гэрэлтүүлэг	100%

						бүхий авто зам тавих ажил хийгдэж дууссан.	
Зорилт 1.7 Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. /ЗГҮАХ 6.1.7/		-	Ажлын явц, хувь	-	Тохижилтын ажлыг хийж, тоосжилтыг тодорхой хувиар бууруулсан байна.	3.47 км явган хүний зам, 3 байршилд авто зогсоол, 3 байршилд тохижилт, тоглоомын талбай байгуулах ажил хийгдсэн. 11 байршилд тоглоомын талбай байгуулж байна.	100%
7	1.7.1 Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор явган хүний зам тавих ажлыг дуусган, ашиглалтад оруулна.	184.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	Ажлын явц 60 хувьтай.	7200 км-ээс доошгүй явган хүний зам ашиглалтад орсон байна.	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хороо 39 дүгээр байрны гадна талбайд 830м2 талбайд, 11 дүгээр хорооны Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд 630м2 талбайд явган хүний зам шинээр тавьсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2, 3, 4, 9, 11, 13, 14, 19, 20 дугаар хороодод 3.47 км урт явган хүний зам тавьж, ашиглалтад оруулсан. Мөн Мишээл экспогоос Яармагийн гүүр хүртэл 1.4 км урт явган хүний болон унадаг дугуйн зам, амралтын талбай бүхий эко зурвасыг байгуулж, ашиглалтад оруулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Зайсангийн гүүрнээс Маршалын гүүр хүртэл Туул голын арын далан дагуух 2.4 км унадаг дугуйн замын ажил хийгдэж байна.	100%
8	1.7.2 2-оос доошгүй байршилд авто зогсоол шинээр байгуулна.	/ДТХО/	Авто зогсоолын тоо	-	2-оос доошгүй байршилд авто зогсоол байгуулагдсан байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 дугаар хороонд, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хорооны 43 дугаар байрны гадна талбайд авто машины зогсоол байгуулсан. Мөн дүүргийн Авто зам засвар, арчлалт ОНӨААТҮГ нь 2 дугаар хороо 30 дугаар байр, 22 дугаар байрны гадна 2 байршилд авто зогсоолын засвар, шинэчлэлийн ажил хийж, гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр гэрээ байгуулагдсан	100%

						“Орчны тохижилт”-ын ажлын хүрээнд 10-р хороо Автомашины зогсоол байгуулах /60/1 дүгээр байрны хойд талбайд/ ажил дулааны улиралд хийгдэнэ.	
9	1.7.3 Нийтийн эзэмшлийн зам талбайд орчны тохижилтын ажлыг гүйцэтгэнэ.	1,120.0 /ДТХО/	Тохижилт хийсэн талбайн тоо	-	8-аас доошгүй байршилд тохижилтын ажил хийгдсэн байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 18 дугаар хорооны Академи хотхон, 20 дугаар хорооны Хөрш заан хотхонд тус тус хүүхдийн тоглоомын талбай байгуулагдсан. Мөн 1, 2, 19, 21 дүгээр хороонд 5 байршилд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын гэрээ байгуулагдсан. Зураг төсөв батлагдах шатанд байна. 2, 19 дүгээр хороонд тоглоомын талбай байгуулах ажил худалдан авах ажиллагааны шатанд байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд 114 дүгээр сургуулийн гадна талбайд спорт тоглоомын талбай байгуулагдаж, ашиглалтад орсон. 1 дүгээр хороо 19 дүгээр байрны гадна талбай, 2 дугаар хороо 1-18, 22, 23-р байрны дунд талбай, АШ-19-р байрны гадна талбай, 28, 29 дүгээр байрны гадна талбай, 15 дугаар хороо Нархан хотхоны гадна талбай, 20 дугаар хорооны 107 дугаар байрны гадна талбай талбайд 6 байршилд тоглоомын талбайн ажил хийгдэж байна. 18, 12, 16, 21 дүгээр хороонд 4 байршилд тоглоомын талбай байгуулах ажлын гэрээ байгуулагдсан. Цаг агаар хүйтэрсэн тул дулааны улиралд ажлыг гүйцэтгүүлнэ. Дүүргийн 2 дугаар хороо, дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд баригдсан орон сууцны барилгуудын дунд дахин орон сууц баригдахаар олгогдсон газрыг иргэд, оршин	100%

						суугчдын хүсэлтээр дүүргийн Засаг даргын зүгээс Нийслэлийн Засаг даргад удаа дараа хүсэлт, албан бичиг хүргүүлсний дүнд газар эзэмших эрхийг цуцлуулж, иргэд, хүүхдүүд салхилах, тоглох тохижилт, ногоон байгууламж бүхий талбай болгон тохижуулсан. Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 110 га талбайд ахмадын чөлөөт цаг өнгөрөөх хэсэг, волейболын талбай, сагсан бөмбөгийн талбай, цэцгийн мандал, цөөрмийн эргийн тавцан, хүүхдийн тоглоомын талбай, гурван хэсэгт голын эргийн тавцан, алсыг харах цамхаг, шинээр тарьсан ховор ургамлуудын хэсэг, түр амрах хэсгүүд бүхий “Мишээл байгаль орчин, танин мэдэхүйн ботаник хүрээлэн” байгуулагдсан.	
Зорилт 1.8 Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна. /ЗГҮАХ6.1.8/		-	Ажлын явц, хувь	-	Эко зурвасыг Яармагийн гүүр хүртэл үргэлжлүүлэн тавьсан байна.	Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл 3.4 км эко зурвас байгуулагдсан.	100%
10	1.8.1 Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл Туул голын эрэг дагуу дугуйн замтай “ЭКО” зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	600.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	2020 онд 1.6 км эко зурвас байгуулсан.	Яармагийн гүүр хүртэл 1,4 км эко зурвас байгуулсан байна.	2020 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороонд Туул голын эрэг дагуу хийгдсэн явган хүний болон дугуйн зам, амралтын талбай бүхий эко зурвасыг 2021 онд Мишээл экспогоос Яармагийн гүүр хүртэл үргэлжлүүлэн гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан. Ингэснээр нийт Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл 3.4 км эко зурвас байгуулагдаж, иргэдэд эрүүл, ээлтэй орчин бүрдсэн.	100%

Зорилт 1.9 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. /ЗГҮАХ 6.2.6/		-	Санал асуулга зохион байгуулсан эсэх	-	Жил бүр санал асуулга зохион байгуулсан байна.	Санал асуулгыг цахим хэлбэрээр 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан.	100%
11	1.9.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахим аппликейшн ашиглан зохион байгуулна.	ҮА-ны зардлаар	Цахим санал асуулга зохион байгуулсан эсэх	-	Цахим санал асуулга зохион байгуулсан байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх ажилд иргэдээс авах санал асуулгыг 2021.03.01-ний өдрөөс 2021.04.01-ний өдрийн хооронд SMART UB аппликейшныг ашиглан цахим хэлбэрээр явуулсан. Цахим санал асуулгад хамрагдах боломжтой 90308 иргэн байгаа гэж тооцоолсноос 56923 иргэн санал өгч, нийт иргэдийн 63%-ийн ирцтэй санал асуулга явагдаж дууссан.	100%
Зорилт 1.10 Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.1/		-	Агаарын бохирдлыг бууруулсан хувь	2018-2020 онд агаарын бохирдлыг 50% бууруулсан.	2021-2024 онд агаарын бохирдлыг 80% бууруулна.	2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 14-ний өдөр хүртэл хугацаанд 28590.4 тн түлшээр, 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 14585тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг тус тус хангасан. “Таван толгой түлш” ХХК-н үйлдвэрээс гардаг сайжруулсан түлшний хэмжээ багассан, дүүргийн 10 дугаар хороо Морингийн даваанд байрладаг “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан түлш савлах бааз байгуулагдан дүүргийн түлш борлуулах цэгүүдэд ойртсон учир хангамжийн 3 бааз ажиллуулах шаардлагагүй болсон.	100%
12	1.10.1 Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын	-	Хангамжийн бааз,	3 хангамжийн бааз, 57 борлуулалтын	3 хангамжийн бааз, 50-аас доошгүй	Дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/570 дугаар захирамжаар байгуулагдсан	100%

	шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.		борлуулалтын цэг, тоо	цэг байгуулсан.	борлуулалтын цэг байгуулна.	ажлын хэсэг сайжруулсан түлшний борлуулалтын цэгүүдийн үйл ажиллагаа, тээвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, мэдээллийг дүүргийн удирдлага, НАБТГ-т хүргүүлж ажиллаж байна. 2020-2021 оны өвлийн улиралд гэр хорооллын айл өрхүүдийг түлшээр хангах 60 борлуулалтын цэг, 3 хангамжийн баазын түлш татан авалт, түгээлтэд тогтмол хяналт тавьж дүүрэг, нийслэлийн Онцгой комиссыг мэдээллээр хангаж ажилласан. 2021 оны 12 дугаар сарын эхний байдлаар 43175тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангаад байна. Дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/600 дугаар захирамжийн дагуу зорилтот бүлгийн айл өрхүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 600 тн түлш нөөцлөх ажил хийгдэж байна.	
13	1.10.2 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр” арга хэмжээг бүсчлэн зохион байгуулна.	5000.0 /ЗДТГ/	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1 арга хэмжээ зохион байгуулсан.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна.	Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2 арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд: 2021 оны 9 дүгээр сарын 11, 12-ны өдөр “Өнтэй өвөлжье” өдөрлөг зохион байгуулж, 13 хорооны 490 орон тооны бус ажилтнууд оролцсон. Өдөрлөгт сэрэмжлүүлэг бүхий гарын авлагаас хороо бүрт байршуулж, 120 гаруй иргэнд мэдээлэл өгч ажилласан. Дүүргийн орон тооны бус ажилтнууд, Онцгой байдлын хэлтэс, хог ачилтын компаниудтай хамтран “Угаарын хийн эрсдлээс сэргийлэх” өдөрлөгийг зохион байгуулж, чанга яригчаар ярьж	100%

						сэрэмжлүүлэг хүргэн, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас өгсөн зөвлөмжүүдийг 16200 айл өрхөд өгсөн.	
14	1.10.3 Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна.	-	Цахим мэдээллийн сан, тоо	-	Тооллогын арга хэмжээ зохион байгуулсан байна.	Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын хэсэг байгуулах тухай” А/1286, дүүргийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 25-ны А/31 дүгээр захирамжийн дагуу агаарын чанарыг сайжруулах 2 дугаар бүс буюу сайжруулсан түлш түлэх 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн бүртгэл, тооллогыг батлагдсан журмын дагуу явуулж, “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан” цахим мэдээллийн системд бүртгэх ажлыг 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс 2 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан” цахим мэдээллийн системд ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух бүртгэгдсэнээс сууцны төрлөөр нь авч үзвэл 42.4 хувь буюу 5319 нь гэрт, 57.6 хувь буюу 7233 нь байшинд ашиглагдаж байна.	100%
Зорилт 1.11 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. /ЗГҮАХ 5.1.4/		Улсын төсөв	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 700-д хүргэнэ	Улсын төсвийн хөрөнгөөр гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулан ажиллаж байна.	100%

15	1.11.1 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	Улсын төсөв	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 700-д хүргэнэ	Улсын төсвийн хөрөнгө 1.4 тэрбум төгрөгийн оруулалтаар Туул голын сав дагуу 12 дугаар хорооны 850, 13 дугаар хорооны 150, нийт 1000 өрхөд MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй нүхэн жорлонг суурилуулж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан. Гүйцэтгэгч: “Хэмжилзүй” ХХК Улсын төсвийн 896,500,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 8, 9, 10 дугаар хорооны 525 өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй нүхэн жорлонгоор шинэчлэх ажил хэрэгжиж байна. Гүйцэтгэгч: “Оргил өргөө” ХХК	100%
Зорилт 1.12 " Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 1.1/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	-	16-аас дээш арга хэмжээ зохион байгуулна.	“Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хүрээнд Хан-Уул дүүрэгт Шуурхай хариу арга хэмжээний баг 24 цагаар эмнэлзүйн тандалт, хариу арга хэмжээг авч ажиллаж байна. Улс, нийслэл болон холбогдох дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, холбогдох судалгаа мэдээллийг шинэчилж, мэдээллээр ханган ажилласан.	100%
16	1.12.1 “Ковид-19” халдварт цар тахлын үед дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага болон тусгаарлан ажиглах байраар ашиглах боломжтой объектын судалгаа, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн	-	Судалгааны тоо, Хэрэгжилтийн хувь	-	4-өөс дээш удаа судалгаа гаргаж, баяжилт хийнэ.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Түр эмнэлэг нээж ажиллуулах тухай” А/228 дугаар тушаалын дагуу дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт эмчилгээний 3 тасаг бүхий “Ковид-21" “150 ортой эмнэлэг”, Туул тосгоны шинэ эмнэлэгт эмчилгээний хөнгөн болон хүндэвтэр өвчтнийг хүлээн авах 2 тасаг бүхий “Ковидын 100 ортой эмнэлэг”-ийг нээн ажиллуулсан. Нийслэлийн Төр захиргааны байранд	100%

	судалгааг тогтмол гаргаж, хянана.					145 ортой эмнэлэг нээн ажиллуулж, нийслэлийн 2300 иргэдийг хүлээн авч, тусламж үйлчилгээ үзүүлсэн. "Ор зохицуулалтын баг", "Эмнэлзүйн зөвлөх баг", "Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх баг"-ууд зохион байгуулагдаж, хуваарийн дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн төв болон Нэгдсэн эмнэлэг, Гамшгаас хамгаалах албаны штабын бүрэлдэхүүнийг шинэчилж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тогтмол тодотгол хийж, цар тахлын хариу арга хэмжээг зохион байгуулан эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцийг бүрдүүлэн ажилласан. Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн эмнэлэг, эмийн сангуудын судалгааг гаргасан. Судалгаагаар нийт 135 эмийн сан, хувийн 64 эмнэлэг /эмч-662, сувилагч-402, бусад ажилчид-743/, Улсын 3 эмнэлэг /эмч-219, сувилагч-193, асрагч-51, бусад ажилчид-223/ ажиллаж байна.	
Зорилт 1.13 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.1.6/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	-	4-өөс дээш арга хэмжээ зохион байгуулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн 5.1.3-т “Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор “Цахим эмч” төслийг хэрэгжүүлж, цахимаар эмчилгээ, зөвлөмжийг хүргэх ажлыг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тусгасан.	70%
17	1.13.1 "Цахим эмч" апплэйкэшин нэвтрүүлж иргэд өөрсдөө чихрийн шижин, цусны даралт зэрэг зонхилон	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Холбогдох цахим үйлчилгээг нэвтрүүлж, хэвшүүлнэ.	Эрүүл мэндийн яамны дуудлагын нэгдсэн "Цахим эмч-119" дугаартай холбох Колл Про үйлчилгээг Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн утсанд холбон нарийн мэргэжлийн эмч нар 24 цагаар иргэдэд эрүүл мэндийн	70%

	тохиолдох өвчнийг өдөр тутам хянах бөгөөд 24 цагийн онлайн зөвлөгөө авах боломжтой болгоно.					зөвлөгөө, мэдээллийг өгч байна. Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх утсаар нийт 15 мянга гаруй иргэдэд зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд тус дүүргийн Нэгдсэн эмнэлгийн харьяанд “Цахим эмч” төв байгуулах төслийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжиж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/538 дугаар захирамжаар тус төвийг байгуулахад шаардагдах төсвийг шийдвэрлэсэн. “Цахим эмч” төв байгуулагдсанаар коронавируст халдварын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд зайнаас буюу цахимаар хүргэх, хянах, зөвлөгөө өгөхөд цахим технологийг ашиглах, хүндэрсэн тохиолдолд хэвтүүлэн эмчлүүлэх, дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх зэрэг цахим эмнэлгийн тусламж, үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх боломж бүрдэнэ.	
Зорилт 1.14 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 2.1.1.7/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	-	4-өөс дээш арга хэмжээ зохион байгуулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрт дүүргийн Эрүүл мэндийн төвд “Эрэгтэйчүүдийн кабинет” байгуулж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, үзлэг оношилгоонд хамруулах” заалтыг тусган батлуулсан.	30%

18	1.14.1 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Кабинет байгуулж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дүүргийн “Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулах” тухай саналыг хүргүүлсэн. Хан-Уул дүүргийн Яармаг салбар амбулаторын Мэс заслын Их эмчийг урологийн эмчээр нарийн мэргэшилд бэлтгэн, иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нийт 400 иргэнд үзлэг, эмийн бус эмчилгээ, 42 иргэнд давсаг болон бөөрөнд гуурс байрлуулах/солих ажилбар хийж, 35 иргэнийг дараагийн шатлалын эмнэлэгт илгээж, мэс заслын эмчилгээнд хамруулсан./	30%
Зорилт 1.15 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. /ЗГҮАХ 2.2.1/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	-	16-аас дээш арга хэмжээ зохион байгуулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн 5.1.6-д “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдний насны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн оюуны болон биеийн тамир спортын олон талт арга хэмжээг дэмжиж ажиллана” заалтыг тусган батлуулсан.	100%
19	1.15.1 "Иргэдийн спортын наадам" 8 төрөлт спортын тэмцээн зохион байгуулж, дараагийн шатны тэмцээнд бэлтгэнэ.	55,0 сая-ДТХО	Спортын төрлийн тоо, Хамрагдсан иргэдийн тоо, Хэрэгжилтийн хувь	Спортын 7 төрөлд 1500 иргэнийг хамруулсан.	4-өөс доошгүй спортын төрөлд 1000 иргэн хамруулна.	Иргэдийг биеийн тамир, спортоор идэвхтэй хичээллүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор “Иргэдийн спортын IX Их наадам”-ыг 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 11-ний хооронд сагсан бөмбөг, гар бөмбөг, олс таталт, ширээний шагайн наадгай	100%

						гэсэн спортын 4 төрлөөр зохион байгууллаа. “Иргэдийн спортын IX Их наадам”-ыг коронавируст халдварын үед авч хэрэгжүүлж буй улс, нийслэл, дүүргийн Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг сахиж, спорт заалны 50%-ийн дүүргэлттэйгээр оролцогчдоос вакцины бүрэн тунд хамрагдсан байх шаардлагыг тавин ажилласан. Тус наадамд 860 гаруй иргэн оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс байгууллагын нэгдсэн дүнгээр: ▪I байр 16 дугаар хороо ▪II байр 8 дугаар хороо ▪III байр 5 дугаар хороо тус тус шалгарсан. Сагсан бөмбөгийн төрөлд 17-р хорооны эрэгтэй баг тамирчид, 2-р хорооны эмэгтэй баг тамирчид, Гар бөмбөгийн төрөлд 3-р хорооны баг тамирчид, Олс таталтын төрөлд 8 дугаар хорооны баг тамирчид, Шагайн наадгайн төрөлд 14 дүгээр хорооны баг тамирчид нийслэлийн шигшээ тэмцээнд оролцох эрх авлаа.	
Зорилт 1.16 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ	Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдсэн байна.	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 арга хэмжээ зохион байгуулж, 598.6 тн мах, 612 тн хүнсний ногоо худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажилласан.	100%
20	1.16.1 Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, хүнсний ногоог хэрэглэгчдэд шууд	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ зохион байгуулж, 512 тн хүнсний ногоо, 385 тн мах худалдан борлуулах	Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдсэн байна	Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд : • Нөөцийн махны худалдааг 34 дэлгүүр болон 26 байршилд өргөтгөсөн худалдааг зохион байгуулж, нийт 598.6	100%

	нийлүүлэх ажлыг зохион байгуулна.			ажлыг зохион байгуулсан.		тонн мах худалдан борлуулж, махны чанар, үнэд хяналт тавьж ажилласан. • Шинэ ургацын ногооны худалдааг 2 байршилд зохион байгуулж, 40 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, 612 тонн хүнсний ногооны борлуулалтыг дэмжин, халдвар хамгааллын дэглэм, ногооны үнэд хяналт тавьж ажилласан. “Хүнсээ бэлтгэе” уриан дор өвлийн идэш арга хэмжээг дүүргийн 15 дугаар хороо Төв цэнгэлдэх, 4 хороо Фүүд сити худалдааны гадна талбайд зохион байгуулж ажилласан.	
Зорилт 1.17 Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ 3.3.13/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ	Үйлдвэрлэл эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	“Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажилласан. Мөн арьс шир, ноос ноолуур, хүнс, эрүүл мэнд зэрэг чиглэлээр 9 удаагийн үзэсгэлэн, арга хэмжээнд давхардсан тоогоор 132 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж ажилласан. Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл, инновацын газартай хамтран байгууллага бүрийн онцлог, үйл ажиллагааны чиглэлд зориулсан старт ап программуудыг худалдаа, үйлчилгээний 143 газарт танилцуулах сургалтыг зохион байгуулсан. Үүнээс 80 байгууллагад 5 төрлийн программыг суулгаж, 2021 оныг дуустал үнэ төлбөргүй ашиглуулсан.	100%
21	1.17.1 “Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл	-	Дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо	20 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.	Дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна	“Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажилласан. 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн цар тахлын нөхцөл байдлын улмаас худалдан авалт багассантай холбогдуулан үйл	100%

	эрхлэгчдийн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжиж ажиллана.					ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож, хүн амын нягтаршил ихтэй байршилд шилжүүлэхээр судалгааны ажил хийгдсэн. Мөн арьс шир, ноос ноолуур, хүнс, эрүүл мэнд зэрэг чиглэлээр 9 удаагийн үзэсгэлэн, арга хэмжээнд давхардсан тоогоор 132 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж ажилласан.	
ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх 21 арга хэмжээ 91.4 хувьтай хэрэгжсэн.							
ХОЁР. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт 2.1. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана. /ҮХ 2.1/		-	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын тоо	3 удаагийн сургалтад 280 албан хаагч хамруулсан.	Төлөвлөгөөт сургалт 2-оос доошгүй, 100 хүртэлх албан хаагчийг хамруулна.	Дүүргийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлуулж, дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны ил тод буланд байршуулсан.	70%
22	2.1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, иргэд, албан хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх ухуулга сурталчилгааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын тоо	3 удаагийн сургалтад 280 албан хаагч хамруулсан.	Төлөвлөгөөт сургалт 2-оос доошгүй, 100 хүртэлх албан хаагчийг хамруулна.	Дүүргийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр батлуулж, дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны ил тод буланд байршуулсан. Төлөвлөгөөнд 6 чиглэлийн 15 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2021 оны А/503 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим	70%

						хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. “Цахим шийдэл” сэдэвт авлигын эсрэг залуусын чуулганы сэтгүүл, Төрийн албаны ёс зүй ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох бодлогын хураамж, Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад зориулсан “Шударга зөв” гарын авлага, хувийн хэвшилд зориулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмж” ,“Хувийн хэвшлийн оролцоо” сэтгүүлийг тус тус дүүргийн 21 хорооны байранд байршуулсан. Төрийн байгууллагын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх 2 удаагийн сургалтад 11 албан хаагчийг хамруулсан.	
Зорилт 2.2 “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. /ҮХ 1/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ	Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	Хүнсний ногооны тариалалтыг дэмжих зорилгоор : ➢ Хөнгөлөлттэй үнээр хүнсний ногооны үр олгосон. ➢ Үйлдвэрлэл эрхлэгч, ногоочдыг дэмжих ажлын хүрээнд 3*3 хэмжээтэй 19.6 сая төгрөгийн үнэ бүхий 8 ширхэг асрыг ЗДТГ-ын төсвөөр хийлгэж, үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд үнэ төлбөргүй ашиглуулсан. ➢ Дүүргийн хэмжээнд "Монгол ногоо" өргөтгөсөн худалдааг 5 байршилд зохион байгуулж, хөдөө орон нутаг, нийслэлийн ногоочдыг дэмжин ажилласан.	100%

						Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл хяналтын систем /https://plant.mofa.gov.mn/-ийг ногоочдод танилцуулах сургалтыг Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулж, 23 ногоочныг хамруулсан.	
23	2.2.1 Хөрс, цаг уурын онцлогт тохирсон хүнсний ногооны үр олгож, өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ зохион байгуулж, хүнсний ногооны үрийг 150 өрхөд олгосон.	Өрхийн тариалалт нэмэгдсэн байна.	Хүнсний ногооны тариалалтыг дэмжих ажлын хүрээнд хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үр хөнгөлөлттэй олгох ажлын хүрээнд • 4 аж ахуйн нэгж 167 иргэнд 664кг нарийн ногооны үр, 300 ширхэг өргөст хэмхийн үрийг хөнгөлөлттэй үнээр олгож, тариалалтыг дэмжин ажилласан. • Үйлдвэрлэл эрхлэгч, ногоочдыг дэмжих ажлын хүрээнд 3*3 хэмжтээтэй 19.6 сая төгрөгийн үнэ бүхий 8 ширхэг асарыг ЗДТГ-ын төсвөөр хийлгэж, үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд 50 хоногийн хугацаанд 16 ногоочинд түрээсийн төлбөргүйгээр ашиглуулсан. Дүүргийн хэмжээнд "Монгол ногоо" өргөтгөсөн худалдааг зохион байгуулан нийт 5 байршилд дүүргийн 7, хөдөө орон нутгийн 28 нийт 35 ногоочны 612 тн ногооны борлуулалтад дэмжлэг үзүүлж ажилласан.	100%
Зорилт 2.3 “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ./ҮХ 2/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн байна.	Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 237 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 55 тогоочид эрүүл хооллолт сэдэвт сургалтыг зохион байгуулсан.	100%

24	2.3.1 Хүүхдийн насны онцлогт тохирсон “Эрүүл хооллолт” сургалтыг ЕБС, цэцэрлэгийн эрхлэгч, тогооч нарт зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	-	Сургууль,цэцэрлэгийн 50 гаруй ажилтныг хамруулж, чадваржуулна.	Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 237 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын хүүхдийн насны онцлогт тохирсон “Эрүүл хооллолт” сэдэвт сургалтын удирдамжийг батлуулж, төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 55 тогооч нарт дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтэс, хүнсний технологийн политехник коллежтэй хамтран онол, дадлагын сургалтыг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлуудад хариулт өгч зөвлөн туслаж ажилласан.	100%
Зорилт 2.4 "Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж иргэд, төрийн албан хаагчдын жендерийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлнэ. /ҮХ 1/		-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь	115 арга хэмжээнд 18656 иргэн хамруулсан.	30-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж 3000 иргэнийг хамруулна.	Хан-Уул дүүргийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Иргэд, төрийн албан хаагчдын жендэрийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаагийн аян өрнүүлж, 8 удаагийн сургалтад 300 гаруй хүнийг хамруулсан. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх постерыг цахим орчныг ашиглан иргэд, олон нийтэд хүргэсэн.	100%
25	2.4.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь	3 аян, 6 сургалтад 18826 иргэн хамруулсан.	10-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж 500 иргэнийг хамруулна.	Жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах зорилгоор “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяныг 2021 оны 3 дугаар сард өрнүүлсэн. Аяны хүрээнд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгааны зарим тодорхой асуудал” цахим хэлэлцүүлэгт дүүргийн Жендэрийн асуудал хариуцсан	100%

						мэргэжилтэн, 21 хорооны Хөгжлийн нийгмийн ажилтнууд оролцсон. -Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, боломж баталгааг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 удаагийн сургалтад 200 гаруй хүнийг хамруулж, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн постер мэдээллийг цахим орчинд түгээж 5321 хүнд хүргэсэн. -“Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх” сургалтад Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, 9 дүгээр хорооны Хөгжлийн нийгмийн ажилтан Л.Дэлгэрмаа нар оролцож сургагч багшийн эрх авсан. -Зэвсэгт хүчний 0326 дугаар ангийн 25 албан хаагчдад “Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт цахим сургалт зохион байгуулсан. -Жендэрт суурилсан хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” 16 хоногийн аянд нийт байгууллага, иргэдийг нэгдэхийг уриалж, сургалт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан.	
Зорилт 2.5 "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх,	-	Үйл ажиллагааны тоо, Үзлэгт хамруулж эрүүлжсэн хүүхдийн хувь	Үзлэгт 16248 хүүхэд хамруулж, 46% нь эрүүлжсэн.	Үзлэгт 30000 хүүхэд хамруулж 50% эрүүлжүүлнэ.	Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт нийт 7312 хүн хамрагдсанаас хүүхдийн үзлэг 2925, үзлэгийн эзлэх хувь өмнөх оноос 27%-иар өссөн үзүүлэлттэй байна.	100%

бууруулах арга хэмжээг зохион байгуулна. /ҮХ 2/							
26	2.5.1 СӨББ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт, үзлэг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны тоо, Үзлэгт хамруулж эрүүлжсэн хүүхдийн хувь	Үзлэгт 7034 хүүхэд хамруулж, 3657 буюу 52% нь эрүүлжсэн.	8 арга хэмжээ зохион байгуулж, үзлэгт хамрагдсан хүүхдийн 20% эрүүлжүүлнэ.	Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт 7312 хүнийг хамруулж, анхдагчаар 5476 хүнд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үзүүлэн 47%-ийг эрүүлжүүлсэн. Үзлэгт 2925 хүүхэд хамрагдсан бөгөөд хүүхдийн үзлэгийн эзлэх хувь өмнөх оноос 27%-иар өссөн байна. Анхдагчаар 1945 хүүхэд үйлчлүүлснээс 816 буюу 42% эрүүлжүүлсэн. Энэ нь өмнөх оноос 12,1%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт урьдчилан сэргийлэх үзлэгээс 131 хүүхэд буюу 7,2% нь эрүүлжсэн. Эмчилгээ хийлгэж буй хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох зорилгоор сургалт хийж, видео бичлэг, амны хөндийн эрүүл ахуйн гарын авлага олгосон.	100%
ҮХ-ийг хэрэгжүүлэх 5 арга хэмжээ 98 хувьтай хэрэгжсэн.							
ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт 3.1 Хүүхдийн зуслан, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. /НЗДҮАХ 5.1.1.1/		-	Ажлын явц, хувь	-	25% /Ногоон байгууламж, бичил цэцэрлэгт хүрээлэн нэмэгдүүлсэн байна./	Эко зуслангийн газрын гэрчилгээ гарч, архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Зөвлөх үйлчилгээний тендер зарлагдах шатанд байна. “Эко ахмадын сувилал” ОНӨААТҮГ-ын гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил хийгдэж дууссан.	90%
27	3.1.1 Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлж, хүүхдийн зуслангийн газрын байршлын судалгаа хийж, зураг төсөл, төсвийг хийлгэнэ.	100.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	-	Эко зуслангийн зураг төсөл, төсвийг хийлгэж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Өөрийн зуслангийн байргүй залуу гэр бүлүүдэд зориулсан “Эко зуслан”-г 14 дүгээр хороонд байгуулахаар төлөвлөн газрын гэрчилгээг гаргуулж, Хот байгуулалт, хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулсан. Зөвлөх үйлчилгээний тендер зарлагдах шатанд байна.	90%

						Мөн 2021 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих “Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын гадна талбайд тохижилт, ногоон байгууламж” хийх ажлыг “Ганхэлхээ констракшн” ХХК гүйцэтгэж дууссан. Дүүргийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/336 дугаар захирамжийн дагуу дүүргийн төсвийн 21,141,000 төгрөгийн санхүүжилтээр нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Ардын Хувьсгалын 25 жилийн ойн өндөрлөгийг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд нийт 15 байршилд 1458 м.кв талбай, аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодтой хамтарч 12002 м.кв талбай, нийт 13460 м.кв талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.	
Зорилт 3.2 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно. /НЗДҮАХ 6.3.30/		-	Ажлын явц, хувь	-	50% Нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлэг нэмэгдсэн байна.	Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбайд 582 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн.	100%
28	3.2.1. Хороодын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооолд 450-аас доошгүй гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, засвар, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ.	900.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	-	Нийтийн эзэмшлийн талбайд 450-аас доошгүй гэрэлтүүлэг суурилуулсан байна.	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 19, 20, 21 дүгээр хороодод нийт 450 ширхэг гэрэлтүүлэг, 20 дугаар хороо Эко зурвасын үргэлжлэл дагуу 44 ширхэг гэрэлтүүлгийг тус тус суурилуулж ашиглалтад оруулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороо Малчны хэсэгт 45 ширхэг гэрэлтүүлгийг суурилуулж дууссан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4 дүгээр хороо,	100%

						Нийслэлийн төр захиргааны байгууллагуудыг Хан-Уул дүүрэг, Яармаг шинэ дэд төвд шилжүүлэн байршуулах болсонтой холбогдуулан ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан авто зам /1.7 км/ дагуух 43 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.	
Зорилт 3.3 Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ. /НЗДҮАХ 6.1.7/		-	Ажлын явц, хувь	-	25% /Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана./	“Андын зам констракшн” ХХК нь Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/438 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Яармаг орчмын ГХДТ-2020-1 багцын “Е” хэсэгчилсэн 39,9 га талбайн 726 нэгж талбарт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр батламжлагдсан.	90%
29	3.3.1 Гэр хорооллын иргэдэд дахин төлөвлөлтийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, иргэдийн хүсэлтийг холбогдох байгууллагуудад уламжлан хамтран ажиллана.	ҮА-ны зардлаар	Сургалт, үйл ажиллагаа-ны хэрэгжилтийн явц, хувь	-	Сургалт, уулзалт зохион байгуулсан байна.	“Андын зам констракшн” ХХК нь Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/438 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Яармаг орчмын ГХДТ-2020-1 багцын “Е” хэсэгчилсэн 39,9 га талбайн 726 нэгж талбарт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчээр батламжлагдсан. “Андын зам констракшн” ХХК Календарчилсан төлөвлөгөөний дагуу газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч иргэдийн 65%-тай гэрээ байгуулсан байна. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөгөөр нийт 726 нэгж талбар чөлөөлөхөөс 90 нэгж талбарыг чөлөөлөн 2021 онд 120 айлын 1 блок орон сууц ашиглалтад оруулсан. 5 дугаар хорооны нутаг дэвсгэр, Яармаг орчмын ГХДТ-2020-1 багцын “Д” хэсэгчилсэн 34 га талбайн дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр “Андын зам констракшн” ХХК шалгаран батламжлагдах шатанд явж байна. Мөн	90%

						6, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт дахин төлөвлөн барилгажуулах төслийн сонгон шалгаруулалтыг зарласан. Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан Гэр хороллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмын 3.4-т Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.2.г-д заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч, төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай дахь 80-аас доошгүй хувийн газар, үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөгч, эзэмшигчтэй гурван талт гэрээ байгуулна гэж заасан.	
Зорилт 3.4 Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцуудыг үе шаттайгаар шинэчилнэ. /НЗДҮАХ 6.1.9/		-	Ажлын явц, хувь	-	Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана.	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 10 байрны дээвэр, 1 байрны фасад, 1 байрны цахилгааны ажил хийгдэж дууссан. 2 байрны фасад засварын ажил хийгдэж байна.	85%
30	3.4.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны оршин суугч иргэдэд дахин төлөвлөлтийн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.	ҮА-ны зардлаар	Сургалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувь	-	Сургалт, уулзалт зохион байгуулсан байна.	10 дугаар хорооны АШХНЗОС 34, 35 дугаар байрнуудын үнэлгээг өнөөгийн ханшаар дахин үнэлэх дүүргийн Засаг даргын захирамж гарсан. 10 дугаар хорооны АШХНЗОС 34, 35, 11-р хорооны Сүрьеэгийн 20, 12-р хорооны 39-р байруудын дахин төлөвлөлтийн ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. 10 дугаар хороо 34, 35-р байрнуудын зах зээлийн бодит цэнийн үнэлгээг мэргэжлийн үнэлгээний байгууллага болох "Мастер үнэлгээ" ХХК-аар гүйцэтгүүлэн, зах зээлийн бодит үнийг тодорхойлуулсан. Тус байрны 96 өрхийг түр суурьшуулах түрээсийн байрны зардлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа	70%

						талаарх хүсэлтийг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 06/426 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт хүргүүлсэн. Ковид-19 цар тахлын улмаас сургалт, уулзалт зохион байгуулаагүй байна.	
31	3.4 2 Нийтийн зориулалттай болон хуучин орон сууц, түүний шугам сүлжээний засвар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ.	1170.0 /ДТХО/	Засварын ажлын явц, хувь	-	5-аас доошгүй нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилтын ажил хийгдсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 30 дугаар байрны дээвэр засварын ажил хийгдсэн, 7, 22 дугаар байрны фасад засварын ажил хийгдэж байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дээврээс нь ус алддаг, дээвэр засварлах шаардлагатай тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан 1 дүгээр хорооны 15 дугаар байр, 2 дугаар хорооны Гаалийн 17 дугаар байр, 22 дугаар байр, 15 дугаар хорооны 53 дугаар байр, 17 дугаар хорооны 104 дүгээр байр, 10 дугаар хорооны 60/1, 66 дугаар байрнуудын дээврийн засварын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 10 дугаар хорооны 62 дугаар байрны дээвэр, 13 дугаар хорооны 1, 6 дугаар байрнуудын дээвэр болон 1 дүгээр байрны фасад, 10 дугаар хорооны 41 дүгээр байрны цахилгааны ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. 2, 3, 10, 19, 20 дугаар хороодод нийт 14 байрны 41 орцны засварын ажил хийгдэж дуусах шатанд байна.	100%
Зорилт 3.5 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах,		-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог	Дүүргийн хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгаж хэвшсэн 18 ЕБС сургууль, 29 цэцэрлэг, 79 СӨХ, 12 аж ахуйн нэгж байгууллагуудын ангилсан,	100%

дахин боловсруулж органик бордоо үйлдвэрлэлтэд дэмжлэг үзүүлж ажиллана. /НЗДҮАХ 5.2.7/					хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ.	дахивар хог хаягдлыг “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2 авто машин, “Мог пластик” ХХК-ны 5 автомашинаар ангилсан хог хаягдлыг тогтмол хуваарийн дагуу ачиж тээвэрлэж байна. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Сууц өмчлөгчдийн дээд холбооноос зохион байгуулсан “Хогоо ангилж суръя” аянд Хан-Уул дүүргийн Сууц өмчлөгчдийн холбоод амжилттай оролцож 8 СӨХ шагналт байранд шалгарсан. Тэргүүн байранд дүүргийн 4 хорооны “Шинэ Өргөө” СӨХ шалгарч зохион байгуулагчдаас хог ангилан ялгах сав байршуулж дэмжлэг үзүүлсэн. “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ нь хүнсний хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд зориулан 13-68 УББ, 13-94 УББ улсын дугаартай автомашинуудыг тоноглож бэлтгэн ажиллаж байна. Дүүргийн 1, 2, 3, 4, 20 дугаар хороодын хоол үйлдвэрлэгч нийт 45 аж ахуй нэгжээс 55 рейсээр 137,5 тонн хоолны, органик хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.	
32	3.5.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, хүнсний хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагад мэдлэг, мэдээлэл	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Дүүргийн хэмжээнд хоол үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ.	“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ нь хүнсний хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд зориулан 13-68 УББ, 13-94 УББ улсын дугаартай автомашинуудыг тоноглож бэлтгэн ажиллаж байна. Дүүргийн 1, 2, 3, 4, 20 дугаар хороодын хоол үйлдвэрлэгч нийт 45 аж ахуй нэгжээс 55 рейсээр 137,5 тонн хоолны органик хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийн хүрээнд “Хоггүй Хан-Уул 2021” хэлэлцүүлгийг зохион байгуулж,	100%

	олгох сургалт зохион байгуулна.					“АПУ” ХХК, “Түмэн шувуут” ХХК, “Е март” зэрэг хүнс үйлдвэрлэгч, борлуулагч томоохон 5 аж ахуй нэгж, хоол үйлдвэрлэгч байгууллагуудад хүнсний хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин эргэлтэд оруулах тухай мэдлэг олгосон.	
33	3.5.2 Гэр хорооллын айл өрхүүдийг галлагаанаас гарсан үнсийг ангилан ялгах ажлыг эхлүүлнэ.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Гэр хорооллын айл өрхийн үнсийг ангилаг ялгах, тусад нь тээвэрлэх ажлыг эхлүүлнэ.	Гэр хорооллын айл өрхүүдэд үнсийг тусад нь хадгалах, ангилах мэдлэг олгох зорилгоор дүүрэг, хороодын цахим хуудаснуудаар дамжуулан мэдээлэл хүргэж, дүүргийн орон тооны бус 525 ажилтнууд, УБЗАА-наас өгсөн зөвлөмжүүдийг 3000 айл өрхөд өгч ажилласан. Гэр хорооллын хороодын 500 өрх үнсээ тусад нь ангилж эхэлсэн.	100%
Зорилт 3.6 Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. /НЗДҮАХ 2.6.3/		-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан иргэний тоо, хэрэгжилтийн хувь	14 арга хэмжээнд 45992 иргэн хамруулсан.	16 үйл ажиллагаа зохион байгуулж 60000 иргэнийг хамруулна.	“Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийн 5.3.2-т “Бүх шатны боловсролын байгууллага, соёлын болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хүүхэд, залуучуудын дунд соёлын боловсрол олгох “Хотын соёл Хан-Уул дүүргээс” олон нийтийн аяныг зохион байгуулна” заалтыг тусган батлуулсан.	100%
34	3.6.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлнэ.	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамруулсан иргэний тоо, Хэрэгжилтийн хувь	2 арга хэмжээнд 1500 иргэн хамруулсан.	4 үйл ажиллагаанд 2000 иргэн хамруулна.	Хотын соёлд суралцах, хотын хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хан-Уул дүүргийн Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг байгуулсан. Мөн Хан-Уул дүүргийн 21 хороонд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулагдсан. Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг хотын соёлд суралцуулах чиглэлээр “Биеэ авч явах соёл” сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 32, 34, 52, 18 дугаар сургуулийн дунд ангийн 251 сурагчийг хамруулсан. Мөн 12 удаагийн сургалтаар дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, ахлах	100%

						бүлгийн 107 сурагчийг “Хотын соёл” хичээлийн хөтөлбөрт хамруулсан. "Харилцааны соёл", "Иргэдийн харилцаа, хандлага", "Дохионы хэлийг соёл болгоё", "E-Mongolia түүний хэрэглээнд суралцъя", "Цагийн менежмент", "Дохионы хэл болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхэд өгөх зөвлөгөө" зэрэг видео хичээл болон иргэдийг олон нийтийн газарт соёлтой, зөв байхад уриалсан постеруудыг цахим сайтуудад байршуулан ажилласан. -Хан-Уул дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, “Хобби ротаракт” клуб, Хан-Уул дүүргийн Залуучуудын нэгдсэн холбоо хамтран "Эко дүүргийн соёлтой залуус" аяны хүрээнд “Хот хоггүй бол гоё” үйл ажиллагааг 2021 оны 8 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд дүүргийн залуучууд нэгдэн, Богд Хан уулын Баруун ширээт оргилын хог хаягдлыг цэвэрлэж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.	
Зорилт 3.7 Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлнэ. /НЗДҮАХ 2.3.7.1/		-	Сургуулийн автобусаар зорчсон хүүхдийн тоо, хэрэгжилтийн хувь	902 хүүхэд сургуулийн автобусаар зорчсон.	2000 хүүхдийг хүүхдийн автобусаар зорчуулна.	2021-2022 оны хичээлийн жилд сургуулийн автобусны үйлчилгээнд хамруулах хүүхдийн судалгааг гаргаж, сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлсэн.	100%
35	3.7.1 "Хүүхдийн автобус" төсөлд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, Хэрэгжилтийн хувь	498 хүүхэд хамрагдсан.	550 хүүхдийг хүүхдийн автобусаар зорчуулна.	2021-2022 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан төрийн болон төрийн бус өмчийн 18 сургуулийн 81 автобусыг үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, коронавируст халдвараас сэргийлэх ажлын хүрээнд халдвар хамгааллыг ханган сурагчдыг тээвэрлэж байна.	100%

						"Сургуулийн автобус" төсөлд тус дүүргийн 15, 18, 32, 52, 75 дугаар сургуулийн 560 гаруй хүүхэд хамрагдаж, “Буянт Ухаа 2-Зайсан”, “Нисэхийн эцэс-120 мянгат”, “Яармагийн эцэс-120 мянгат” чиглэлд "Хүүхэд зохицуулагч" нар сургуулийн захиргаатай гэрээ байгуулан ажиллаж байна. 114-р сургуулийг "Сургуулийн автобус" төсөлд хамруулахаар нийслэлийн Боловсролын газарт хүсэлт хүргүүлсэн.	
Зорилт 3.8 Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчныг бүрдүүлнэ. /НЗДҮАХ 2.3.4.1/		-	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо	336 хүүхэд хамрагдсан.	450 хүүхэд хамруулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Багш” дэд хөтөлбөрийн 5.1.6-д “Багш бүрд тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах ур чадварыг эзэмшүүлнэ” заалтыг тусган батлуулсан.	100%
36	3.8.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо, Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, Хэрэгжилтийн хувь	2 удаагийн сургалтад 200 захирал, эрхлэгчийг хамруулсан.	4 үйл ажиллагаа зохион байгуулж 250 хүүхдийг хамруулна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам"-ын хүрээнд цэцэрлэгүүд дэмжлэгийн баг байгуулж, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 54 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулсан. Хан-Уул дүүргийн 63 дугаар сургуулийн мэргэжлийн багш нартай хамтран тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах талаарх мэдлэг олгох цахим сургалтыг сургууль, цэцэрлэгийн "Дэмжлэгийн баг"-ийн 164 гишүүдэд зохион байгуулсан. Төрийн өмчийн 19 сургуулийн захирал, 28 цэцэрлэгийн эрхлэгч нарт “Боловсролын тусгай	100%

						хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд, сургалтын орчин-хамтын ажиллагаа”-тай танилцах сургалтыг зохион байгуулсан. Мөн дүүргийн 21 хороо, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд "Боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг илрүүлэн, сургуульд суралцахын ач холбогдол, үр дүн" мэргэжлийн зөвлөгөөг 63 дугаар сургуультай хамтран зохион байгуулсан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” 3 модуль сургалтад бага ангийн 13 багшийг хамруулж, сургагч багшаар бэлтгэсэн.	
Зорилт 3.9 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ. /НЗДҮАХ 2.5.1/		-	Хамруулсан иргэний тоо, Хэрэгжилтийн хувь	16 баг шалгаруулж санхүүжилт олгосон.	15 баг шалгаруулж санхүүжилт олгоно.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар тогтоолоор иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус баталсан.	70%
37	3.9.1 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гарааны бизнес эрхэлж орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	5 баг шалгаруулж санхүүжилт олгосон.	4 арга хэмжээ зохион байгуулж 2 баг шалгаруулна.	Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн мэдээллийг иргэдэд видео хэлбэрээр болон Han-Uul.hudulmur-halamj.gov.mn, Khanuul.mn сайтууд, Хан-Уул дүүрэг, Хөдөлмөр халамж фэйсбүүк хуудас, 21 хорооны цахим болон мэдээллийн самбарт байршуулсан. Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэдэх Залуучуудын хөдөлмөр	70%

						эрхлэлтийн үйлчилгээний загвар төв нь 18-34 насны 20 залууд онлайн орчинд Zoom програмыг ашиглан 5 модуль бүхий сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан залуучуудыг "АПУ", "ГОВЬ" ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулж, байнгын ажлын байранд зуучлагдах, эзэмшсэн мэргэжлийн дагуу туршлага эзэмшүүлэх зорилгоор “Интерншип” хөтөлбөрт хамруулахаар төлөвлөсөн. /2021 оны төсвийн хуваарь шинэчлэгдэж, шилдэг "Старт-ап" 2 багийг сонгон шалгаруулах, “Старт-ап” залуучуудад ментор хийх зардлыг буцаан татсан./	
Зорилт 3.10 Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулна. /НЗДҮАХ 2.7.1.3/		-	Шалгарсан байгууллагын тоо, Хэрэгжилтийн хувь	20 байгууллага шалгаруулсан.	20 байгууллага шалгаруулна.	Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дүүргийн Боловсролын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, хороодтой хамтран олон талт үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Тухайлбал: ▪ “Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр” ▪ “Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага” ▪ “Шилдэг гэр бүл”, ▪ “Гэр бүлийн өдөр”	100%
38	3.10.1 “Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага", "Шилдэг гэр бүл"-ийг шалгаруулж олон нийтэд сурталчилна.	-	Шалгарсан байгууллагын тоо, Хэрэгжилтийн хувь	5 байгууллагыг “Хүүхэд гэр бүлд ээлтэй” байгууллагаар шалгаруулсан.	5 байгууллага шалгаруулна.	Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт ойг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ”Нийслэл хотын шилдэг гэр бүлийг алдаршуулах” арга хэмжээг Хүмүүнлэг, Оюунлаг, Бүтээлч, Спортлог, Өв соёлоо түгээн дэлгэрүүлэгч 5 номинациар	100%

						шалгаруулж, иргэд, олон нийтэд алдаршуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Хан-Уул дүүргээс номинаци тус бүрд шилдэг өрхүүдийн мэдээллийг хүргүүлснээс “Оюунлаг гэр бүл”-ээр 11 дүгээр хорооны иргэн Б.Насанбат, “Хүмүүнлэг гэр бүл”-ээр 11-р хорооны иргэн Г.Банзрагч нарын гэр бүл шилдгээр шалгарсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны А/376 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газруудыг хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр уриалах, нийгмийн хариуцлага, идэвх санаачилгыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага” шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаж, “Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага”-д Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, 32 дугаар сургууль, 34 дүгээр сургууль, 65 дугаар цэцэрлэг, “Амин хүүхэд” ТББ, Emart худалдааны төвийн материалыг нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.	
Зорилт 3.11 Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулна. БЗДХ/ДОХ, халдварт гепатит, бусад халдварт болон халдварт бус	-	Үзлэг, нөлөөллийн арга хэмжээний тоо,	Халдварт бус өвчний эрт илрүүлэгт 463802 иргэн, халдварт өвчний эрт	Халдварт бус өвчний эрт илрүүлэгт 50000 иргэн, халдварт өвчний эрт илрүүлэгт 60000 иргэн хамруулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн 5.1.4-т “Өсвөр үе, хүүхэд, залуучуудад БЗДХ/ХДХВ/ДОХ-оос	100%

өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна. /НЗДҮАХ 2.1.1.1, 2.1.2/			Хэрэгжилтийн хувь	илрүүлэгт 52726 иргэн хамруулсан.		урьдчилан сэргийлэх эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар сургалт сурталчилгаа, сайн дурын зөвлөгөө, шинжилгээний үйл ажиллагааг зохион байгуулна” заалтыг тусган батлуулсан.	
39	3.11.1 БЗДХ/ДОХ, халдварт гепатит, бусад халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна.	-	Үзлэг, нөлөөллийн арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	241 иргэнийг үзлэгт хамруулсан.	4 үзлэг, 4 арга хэмжээ зохион байгуулна.	ДОХ/БЗДХӨ-ний урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 3049 иргэнийг хамруулж, 18 өвчлөлийг эрт илрүүлэн 100 хувь эмчилгээнд хамруулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Их дээд сургууль, Коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн оюутан, залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Эрүүл оюутан-Эерэг хандлага” сарын аяныг зохион байгуулсан. Аяны хугацаанд Монгол Солонгосын Политехникийн коллеж, Механик тээврийн сургууль, Технологийн дээд сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулиудын нийт 1269 оюутан залуучуудыг сүрьеэ, өсвөр үе, охид, бэлгийн замаар дамжих халдвар гэсэн 4 чиглэлээр үзлэг, шинжилгээнд хамруулсан. -Дүүргийн нутаг дэвсгэрт орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдийг бүртгэлжүүлж, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн төв, Хан-Уул дүүрэг Цагдаагийн газар, Улаан загалмайн хороотой хамтран 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. -Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг	100%

						тогтоолгож буй нөхөн үржихүйн насны 25 эмэгтэйг эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулж, ДОХ/БЗДХ, элэгний В,С вирус илрүүлэх, хөх, умайн хүзүүний эрт илрүүлэгт үзлэгт оруулсан. -“Зохистой хооллолт”, “Чихрийн шижин өвчний хоол шим тэжээл”, “Даралт ихсэх өвчний үеийн хоол шим тэжээл”, “Цусан дахь өөх тос ихсэх өвчний үеийн хоол шим тэжээл”, “Хөхүүл эхийн хоол шим тэжээл”, “Жирэмсэн эхийн хоол шим тэжээл”, “Хүүхдийн нэмэлт хоол”, “Томуу томуу төст өвчний үеийн хоол шим тэжээл”, “Бөөрний өвчний хоол шим тэжээл”, “Элэг цөсний өвчний хоол шим тэжээл”, “Ходоодны өвчний хоол шим тэжээл”, “Зүрх судасны өвчний хоол шим тэжээл”, “Яс сийрэгжилтийн үеийн хоол шим тэжээл”, “Цус багадалтын үеийн хоол шим тэжээл” зэрэг 14 сэдвээр цахим сургалт зохион байгуулж, 600 гарын авлага, сурталчилгааны материалыг бэлтгэж тараасан. -Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын эрүүл мэндийн боловсрол, ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эерэг зан үйлд сургах зорилгоор ХДХВ/ДОХ-д анхаарлаа хандуулах дэлхийн өдрийг тохиолдуулан “ХДХВ/ДОХ, Хүчирхийллийн эсрэг хамтдаа” уриан дор эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан.	
Зорилт 3.12 Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулж, хүн амын хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 арга хэмжээ	Мал, амьтны халдварт өвчлөл буурна.	Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах зорилгоор дүүрэг Мэргэжлийн хяналтын хэлтэс, Мал эмнэлгйин тасагтай хамтран мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйл	100%

мэндийг хамгаална. /НЗДҮАХ 3.3.6/						ажиллагаатай танилцаж 2020 оны ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж, зөрчил дутагдлыг арилгуулж 2021 онд ажил гүйцэтгэх гэрээ байгуулан мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилласан. Үүнд : - Махны өргөтгөсөн худалдаа Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл, хяналт	
40	3.12.1 Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Үйл ажиллагааны хэрэгжилт 85 хувь	Нийт мал сүргийн 90-95 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулна.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх мал, амьтаыг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд : • Малын хашаа саравч, өтөг бууц тэжээлийн агуулах, түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг, худаг уст цэг зоорь агуулах бүхий нийт 226 объектын 36780 мкв талбайг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулсан. • Мал, амьтны 280 гаруй сэг зэмийг Хан-Эко тээвэр ОНӨААТҮГ-ын захиргаатай хамтран хогийн цэгт устгаж халдваргүйжүүлсэн. • Мал амьтны гоц халдварт, халдварт 13 /боом, галзуу, адууны томуу, гахайн мялзан, шувууны тахал, үхрийн дуут хавдар, хонь, ямааны дотрын халдварт хордлого, цусан халдварт, гахайн ёлом, гахайн цусан халдварт, шувууны цусан халдварт/ өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг давхардсан тоогоор 420.600 толгой мал, амьтан /адуу, үхэр, хонь, ямаа, гахай, нохой, шувуу/ хамруулахаар төлөвлөснөөс 414.222 толгой мал, амьтан хамрагдаж 98.4 хувийн гүйцэтгэлтэй хийж дуусгасан.	100%

						• Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 38.732 өвчинд мэдрэмтгий мал, амьтан хамрагдахаас 38.238 хамрагдаж 98.7 хувийн гүйцэтгэлтэй хийж дуусгасан. • Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 12, 13, 14-р хорооны малчин өрхийн охин тугал, хурга, ишгэнд хийсэн. Дархлаажуулалтад дүүргийн хэмжээнд 4.060 толгой төл мал хамруулахаас: • Тугал-1237 • Хурга-1406 Ишиг-1243 нийт 3.886 толгой малыг хамруулж 95.7 хувийн гүйцэтгэлтэй дуусгасан.	
Зорилт 3.13 Хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /НЗДҮАХ 6.1.5/		-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	6	Стандартын хэрэгжилт хангагдана.	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран давхардсан тоогоор 8 чиглэлээр хяналт шалгалтыг 11485 иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийж зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.	100%
41	3.13.1 Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулж стандартыг мөрдүүлж ажиллана.	-	Хяналт шалгалтын тоо	2	Стандарт, дүрэм журмын хэрэгжилт хангагдана.	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг аттестатчилах тухай” 2021 оны А/141 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, сунгагдах худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд аттестатчиллын шалгалтыг 2 үе шаттайгаар дүүрэг дэх Цагдаагийн газар, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран аттестатчиллын шалгалтад хамрагдсан нийт 393 аж ахуйн нэгжээс стандарт шаардлага хангасан 283 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр	100%

						үйлчлэх тусгай зөвшөөрөл олгуулахаар дэмжин материалыг хүргүүлж, стандарт шаардлага хангахгүй 15 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг УБХЗАА-нд хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын удирдамж”-ийн дагуу дүүргийн Цагдаагийн газар, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран 78 иргэн, аж ахуйн нэгжид 2 удаагийн хяналт шалгалтыг хийж 29 зөрчлийг илрүүлж, төлбөрийн баримт олгодоггүй 16 иргэн, аж ахуйн нэгжид Татварын хэлтсийн улсын байцаагчийн шаардах хуудсыг хүргүүлж, бичиг баримтын зөрчилтэй 12 иргэн, аж ахуйн нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулан ажилласан. Үүнд: • Татварын хууль тогтоомж зөрчсөн 17 • Бичиг баримтын зөрчилтэй 12 - Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр нөөцийн махны худалдааг 34 дэлгүүрт, өргөтгөсөн худалдааг 11 өдөр давхардсан тоогоор 26 байршилд гаргаж нийт 598.6 тонн нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. Дээрх ажилд УБ хотын ЗАА, ЦГ, МХХ-тэй хамтран давхардсан тоогоор нийт 340 иргэн, аж ахуйн нэгжид халдвар, хамгааллын	

						дэглэмийг мөрдүүлж хяналт тавьж ажилласан. Худалдаа үйлчилгээний газруудад халдвар хамгааллын дэглэм, түр журам, тусгай нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хамтарсан хяналт шалгалтыг дүүргийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хяналт тавьж, зөвлөн тусалж ажилласан. 2021 онд давхардсан тоогоор 158 албан хаагч, 10674 иргэн, аж ахуйн нэгжид хяналт тавьж, 4280 зөрчил илрүүлж 76 хувийг арилгуулан ажилласан.	
НЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх 15 арга хэмжээ 95.3 хувьтай хэрэгжсэн.							
ДӨРӨВ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт.4.1 Төрийн байгууллагуудад үйл ажиллагаагаа хэвийн явуулах, иргэдэд саадгүй үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. /ДЗДҮАХ 3.3.1/		-	Хэрэгжилтийн хувь	-	25% /Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн дээвэр, фасадыг засварлана./	Цагдаагийн 1, 2 дугаар байрны дээвэр болон фасад засварын ажил хийгдэж дууссан.	100%
42	4.1.1 Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн байрны фасад болон дээврийн засварын ажлыг гүйцэтгэнэ.	220.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	-	Барилгын дээвэр, фасадын ажил хийгдэж дууссан байна.	Ажлын тоо хэмжээний судалгааг хийсэн бөгөөд, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн дээвэр, фасадны засварын зураг төсвийг “Аббадон” ХХК-аар, барилгын засварын ажлыг “Улаан элс” ХХК-аар гүйцэтгүүлэн, хүлээж авсан.	100%
Зорилт 4.2 Түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг засаг захиргааны анхан шатны нэгж болох хороог ажлын албатай болгоно. /ДЗДҮАХ 3.3.4/		-	Хэрэгжилтийн хувь	-	25% /2 хорооны барилгыг эхлүүлсэн байна./	2 байршилд хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж, гэрээ байгуулагдсан. Зураг, төсвийн ажил хийгдэж байна. 2 байршилд хорооны барилга худалдан авсан байна.	100%
43	4.2.1 Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгыг шаардлагатай	3,000.0 /ДТХО/	Ажлын явц, хувь	-	2 байршилд хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын	Дүүргийн төсвөөр 2021 онд 11, 19 дүгээр хороодод хорооны барилгын орон сууц худалдан авсан.	100%

	хороодод байгуулах ажлыг эхлүүлнэ. /ДЗДҮАХ 4.40.1/				ажлыг эхлүүлсэн байна.	Мөн төвийн болон нисэхийн бүсэд “Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга”-ыг барихаар төсвийг баталсан. Үүний дагуу нисэхийн бүсийн хорооны цогцолбор барилгыг 21 дүгээр хороонд байрлах “Солонго-1” хороллын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газарт барилгажуулахаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, “Жигүүр-Эрдэнэ” ХХК-тай гэрээ байгуулсан. Зураг төсөв хийгдэж байна. Төвийн бүсийн хорооны цогцолбор барилгыг 15 дугаар хорооны нутаг дэвсгэр, “Рапид харш” орон сууцны хороллын баруун хойд талд “Ар Ви Жи Эйч” ХХК-д биеийн тамир, спортын зориулалтаар олгогдсон газрын эзэмших эрх Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/394 дугаар захирамжаар хүчингүй болж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/297 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт олгогдсон 3700 м2 газарт барилгажуулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Чингисийн төгөл” ХХК-тай гэрээ байгуулсан. Зураг төсөв хийгдэж байна. Тус ажлууд 2022 онд он дамжин хэрэгжиж дуусна.	
Зорилт 4.3 Ахмадын сувилал, асрамжийн газруудыг шинээр байгуулна. /ДЗДҮАХ 4.2.5/		2063.0 /ДТХО/	Хэрэгжилтийн хувь	-	100% /./Ахмадын сувилал ашиглалтад орсон байна./	Ахмадын сувиллын барилгын ажлыг улсын комисс хүлээн авсан, тоног төхөөрөмж нийлүүлэх, гадна тохижилт, ногоон байгууламж хийх ажлууд дууссан.	100%
44	4.3.1 Эко ахмадын сувилалд шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг	1,095.0 /ДТХО/ НОНХС	Ажлын явц, хувь	Барилгын ажлын явц 90%	100% /Эко Ахмадын сувилал ашиглалтад орсон байна./	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Эко ахмадын сувилал”-ын барилгын ажлыг “Голден лайт” ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд улсын комисс ажиллаж, хүлээн авсан.	100%

	нийлүүлэн, бүрэн ашиглалтад оруулж, гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгүүлнэ.					Шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр "Дегамонгол" ХХК, Хашхан" ХХК-ууд шалгарч, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж дууссан. Гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр “Ганхэлхээ констракшн” ХХК шалгарч, ажил гүйцэтгэж дууссан.	
Зорилт 4.4 Хог хаягдлын тээврийн машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 4.14.3/		-	Хэрэгжилтийн хувь	-	70% /Хог тээврийн авто машин хэвийн даацтайгаар ажилладаг болсон байна. /	10 ширхэг хог тээврийн болон цэвэрлэгээний автомашин авах ажлын худалдан авах ажлын гэрээ байгуулагдсан. Автомашинууд угсрагдаж дууссан.	90%
45	4.4.1 Хог тээврийн авто машины парк шинэчлэлт хийнэ.	2,096.0 /ДТ/	Шинээр авах хог тээврийн машин, тоо	-	10-аас доошгүй хог тээврийн авто машин нийлүүлэгдсэн байна.	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021 онд 10 ширхэг хог тээврийн болон цэвэрлэгээний авто машин худалдан авахаар 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр тендер зарлаж, "Хьюндаймоторс монгол" ХХК, "Батсээр" ХХК-ууд шалгарч, гэрээ байгуулагдсан. Авто машинууд захиалгийн дагуу үйлдвэрлэгдсэн. 4 машин нийлүүлэгдсэн, 6 машин тээвэрлэлтийн шатандаа явж байна. Короновирусын онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор БНХАУ-н хил хааснаас шалтгаалан тээвэрлэлт удааширсан байдалтай байна.	90%
Зорилт 4.5 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.4.1/		-	Хэрэгжилтийн хувь	-	25% /Жил бүрийн төсвийг хугацаанд нь батлуулсан байна.	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг улс, нийслэлийн төсөв, улс, нийслэл, дүүргийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан.	98%

46	4.5.1 Дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг бодлогын баримт бичгүүд болон бусад эх үүсвэрийн төсвийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж батлуулна.	ҮА-ны зардлаар	Орон нутгийн төсвийг хуулийн хугацаанд батлуулсан эсэх.	-	2022 оны төсвийн төлөвлөлтийг хийж, 2021.12.20-ны өдрийн дотор ДИТХ-ын тогтоолоор батлуулна.	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг улс, нийслэлийн төсөв, улс, нийслэл, дүүргийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулж, төлөвлөлтийг хийсэн. Жагсаалтыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулсан.	100%
47	4.5.2 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн ажил болон дүүргийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, нэгжийн дарга болон байгууллагын даргаар батлуулан Худалдан авах ажиллагааны албанд ажлын зураг төсөв болон холбогдох бусад материалын хамт шилжүүлнэ.	ҮА-ны зардлаар	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	Төсөл, арга хэмжээнүүдийн тендер зарлахад шаардагдах баримт бичгүүдийг “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд заагдсан хугацаанд ХУДХААА-нд бүрэн хүлээлгэн өгнө.	Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих 4 ажил, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 16 ажлын худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирснийг Худалдан авах ажиллагааны албанд бүрэн хүлээлгэн өгсөн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 31, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 2, нийт 33 төсөл, арга хэмжээг 2021 онд шинээр хэрэгжүүлэхээс 31 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. 2 ажлын архитектур төлөвлөлтийн даалгавар хүлээгдэж байна. Тус 2 ажлыг он дамжуулан, хэрэгжүүлнэ.	96%
Зорилт 4.6 Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцыг авто зам дээгүүр барих ажлыг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 5.3.3/		-	Ажлын явц, хувь	-	10% /Нүхэн гарцны ажлыг эхлүүлсэн байна./	Дүүргийн 4 дүгээр хороо Хүннү моллын автобусны буудлын орчимд нүхэн гарц барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулагдсан. Зураг төсөв хийгдэж байна.	100%
48	4.6.1 Яармагт Наадамчдын зам дагуу явган хүний	2,000.0 ДТХО	Ажлын явц, хувь	-	20% /Нүхэн гарцын ажлыг эхлүүлсэн байна./	Дүүргийн 4 дүгээр хороо Хүннү моллын автобусны буудлын орчимд нүхэн гарц барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулагдсан.	100%

	нүхэн гарцын ажлыг эхлүүлнэ.					Зураг төсөв хийгдэж байна. Захиалагчийн хяналтын Нийслэлийн Авто замын хөгжлийн газраар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулагдсан. Ажил 2022 онд он дамжин хэрэгжиж дуусна.	
Зорилт 4.7 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 1.1.3/		-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Ногоон байгууламж, мод, бут, сөөгийг бүртгэлжүүлж, мэдээллийн сан үүсгэнэ.	Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийг боловсруулж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус дэд хөтөлбөрийн хүрээнд дүүргийн хэмжээнд шинээр байгуулагдах хүүхдийн тоглоомын талбай, 2000 м.кв хүртэлх талбай, 4000 м.кв хүртэлх талбай, 8000 м.кв хүртэлх талбай, 10000 м.кв хүртэлх талбайн тохижилтын ажилд мөрдөгдөх үлгэрчилсэн загварыг боловсруулж, шинээр хэрэгжих тохижилтын ажлуудад загвар болгож ашиглахаар шийдвэрлэсэн. Мөн мэргэжлийн байгууллагатай хамтарч Туул голын сав дагуу 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлж, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Дүүргийн 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн орчимд нийт 2326.48 га талбай эвдрэлд өртсөнөөс эвдрэлд сул өртсөн	100%

					талбай 943.3 га, дунд зэрэг өртсөн 257.04 га, хүчтэй өртсөн 1126.48 га талбай байна. Явган алхалтын холбоо ТББ-тай хамтарч Богдхан ууланд олон улсын явган алхалтын тэмдэг, тэмдэглэгээний стандартыг нэвтрүүлсэн "Явган алхалтын зам"-ыг байгуулахаар ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр Наадамчдын зам, Махатма Гандийн гудамжинд 3452 м.кв талбай, дүүргийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/336 дугаар захирамжийн дагуу дүүргийн төсвийн 21,141,000 төгрөгийн санхүүжилтээр нийт 15 байршилд 1458 м.кв талбай, аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодтой хамтарч 12002 м.кв талбай, нийт 13460 м.кв талбайг зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан. Дүүргийн Засаг даргын 2021 оны А/61 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн ногоон байгууламжийг тоолж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрээр ногоон байгууламжийг ургамлын төрөл зүйлээр нь ангилж, нарийвчлан судалж, тоолж, бүртгэлжүүлж газарзүйн мэдээллийн системд суурилсан орон зайн цахим мэдээллийн санг үүсгэсэн. Дүүргийн 1 дүгээр хорооны ногоон байгууламжийг 99 нэгж талбар үүсгэж бүртгэлжүүлсэн. Тус мэдээллийн сангаар 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байгаа 86354,2 м.кв талбай бүхий ногоон байгууламжид зүлэгжүүлсэн газар 71744,5 м.кв	

						талбай, ургамлан хашлага 1924,3 урт метр, цэцгийн мандал 9 ширхэг, модлог ургамал 3189 ширхэг байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн суурьшлын бүс газрын 0.9 хувь буюу 156.1 га талбайд ногоон байгууламж бүхий талбай эзэлж байна.	
49	4.7.1 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор “Бүх нийтээр мод тарих өдөр” арга хэмжээг зохион байгуулна.	40000.0 /ДТ/	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	“Бүх нийтээр мод тарих өдөр” хаврын арга хэмжээг зохион байгуулна.	“Бүх нийтээр мод тарих өдөр” намрын арга хэмжээг зохион байгуулна.	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/243 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/244 дүгээр захирамжийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг дүүргийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж, хяналт тавьж ажилласан. Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 85028 ширхэг мод, бут, сөөгийг шинээр тарьсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Ногоон хэрэм төслийн талбайд зохион 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, нийт 3191 ширхэг мод, бут, сөөгийг тарьсан. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран зохион байгуулсан “Өрх бүр хашаандаа мод тарья” арга хэмжээний хүрээнд 13 хорооны 464 айл өрхөд нийт 3250 ширхэг мод, бут, сөөгний суулгац, дүүргийн Засаг даргын Тамгын газраас 10, 16 дугаар хорооны 100 айл өрхтэй хамтарч 750 ширхэг чацаргана, 250 ширхэг үхрийн нүдний суулгацыг тарьсан.	100%

						Намрын бүх нийтийн мод тарих арга хэмжээний хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд 9, 10, 16 дугаар хорооны 100 айл өрхтэй хамтарч 750 ширхэг чацаргана, 250 ширхэг үхрийн нүд тарьсан. Дүүргийн 8 дугаар хороо, оюутан залуустай хамтарч “Нэг жилд – Нэг мянган мод” төслийг санаачлан хэрэгжүүлж, 3,500,000 төгрөгийн хөрөнгөөр 250 өрхтэй хамтарч 1000 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан.	
Зорилт 4.8 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 5.4.1/	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын парк шинэчлэлтийг хийсэн байна. Хог тээврийн шинэ байгууллагын үйл ажиллагааг жигдрүүлсэн байна.	Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийг боловсруулж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор "Хоггүй Хан-Уул 2021" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуй нэгжийн төлөөл бүхий 40 гаруй хүн оролцож үр дүнд нь дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах 4 бүлэг 11 үйл ажиллагаа бүхий "Зөвлөмж" гарсан. Дүүргийн хог тээврийн байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ-г шинээр байгуулж 2021	100%

						оны 11 сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаа эхлэн, 1,2,19,20 дугаар хорооны хог тээвэрлэлтийг хариуцан үйл ажиллагаа жигдэрсэн.	
50	4.8.1 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлж бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулна.	40000.0 /ЗДТГ/	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	10 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулсан.	8-аас доошгүй удаагийн “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулсан байна.	Хог хаягдлыг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоод, иргэдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим орчинд нийт 5 богино хэмжээний видео, шторкуудыг бэлтгэж “Хан-Уул Эко дүүрэг”, “Нээлттэй Хан-Уул”, “Хан-Уул дүүргийн иргэд” цахим хуудаснууд болон 21 хорооны цахим хуудаснуудаар байршуулж, сурталчилж ажилласан. Туул гол дагуу иргэдийн амарч, салхилдаг хэсгүүдийн 12 байршилд “Байгаль эх дэлхийгээ хайрлая, Хог бүү хая” анхааруулах самбарыг хийж байршуулсан. Дүүргийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжийн дагуу “Хоггүй Хан-Уул 2021” аяны хүрээнд зохион байгуулсан 8 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 3185 аж ахуйн нэгж байгууллага, 268 СӨХ-ны 21768 ажилтан албан хаагч, иргэд оролцож 671090 м2 талбайгаас 450,6 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.	100%
51	4.8.2 Харшлын өвчин үүсгэгч шарилж, хөл газрын ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	3000.0 /ДТ/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	“Шарилжгүй Улаанбаатар” аяныг хэрэгжүүлж ажилласан.	“Шарилжгүй эрүүл дүүрэг” аяныг зохион байгуулсан байна.	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжийн дагуу “Шарилжгүй Улаанбаатар” аяны хүрээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж, 1280 аж ахуйн нэгж, байгууллага, 268 сууц өмчлөгчдийн холбооны 4700 ажилтан, албан хаагч нар оролцож, нийт 108450 м.кв талбайгаас 282,6 тн шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэсэн байна.	100%

Зорилт 4.9 Дүүргийн гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлнэ. /ДЗДҮАХ 5.4.1/		-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Төсөл арга хэмжээнүүдэд нэгдсэн стандартыг мөрдүүлсэн.	Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдэд нэгдсэн стандартыг мөрдүүлсэн байна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 онд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөгжлийн хөрөнгөөр тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр хэрэгжиж буй 47 төсөл төсөл арга хэмжээний ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлж, ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажилласан.	100%
52	4.9.1 Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тохижилт, ногоон байгууламжийн ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, %	төсөл арга хэмжээнүүдэд нэгдсэн стандартыг мөрдүүлсэн.	Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдэд нэгдсэн стандартыг мөрдүүлсэн байна.	Дүүргийн төсвийн 104.0 сая төгрөгийн хөрөнгөөр 38, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр 23 тоглоомын талбайг засварлуулж, стандарт, орчны аюулгүй байдлыг хангуулсан. Дүүргийн төсвийн 918.5 сая төгрөгийн хөрөнгөөр 9, 10, 11, 12, 13, 14, 16, 19, 20, 21 дүгээр хороонд шинээр 450 ширхэг, Нийслэлийн төсвийн 75.6 сая төгрөгийн хөрөнгөөр 12 дугаар хороонд шинээр 45 ширхэг, Туул гол дагуух Эко зурвас байгуулах ажлын хүрээнд 50 ширхэг гэрэлтүүлэг шинээр хийж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлгийг 545 ширхгээр нэмэгдүүлсэн. Газар зохион байгуулалтын албатай хамтарч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, стандартыг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/250 дугаар захирамжийн хүрээнд 14,600,000 төгрөгийн зардлаар дүүргийн 3, 8, 14, 18, 20, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбай хаасан, зөвшөөрөлгүй хашаа барьсан зэрэг 22 байршилд зөрчлийг илрүүлж 96816 м.кв талбайг бүрэн	100%

						чөлөөлөх арга хэмжээ авч ажиллалаа. Газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах, газар ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжийн 2021 оны А/352 дугаар захирамжийн хүрээнд 8, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 7 байршилд 39600 м.кв талбайд зөвшөөрөлгүй барьсан хашааг албадан буулгаж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлөх арга хэмжээ авч ажилласан. Аж ахуйн нэгж байгууллагын өнгө үзэмжгүй хашаа хайсыг буулгах, угааж арчлах, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй ТҮЦ, сүүдрэвч самбар шон гадас зэргийг авах ажлын хүрээнд зөвшөөрөлгүй болон хүний хөдөлгөөнд саад учруулж буй 1, 2, 3 дугаар хороонд 3,713,000 төгрөгийн зардлаар 41 байршилд 521 урт метр хайс, хашлага, 140 ширхэг шон гадсыг буулгаж, 6 ТҮЦ нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлж ажилласан.	
Зорилт 4.10 Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл", "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл" олгон гэрээ байгуулж, хяналт тавих, усны мэдээллийн санд бүртгэнэ. /ДЗДҮАХ 5.6.1/		Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллага, тоо	13 байгууллагад зөвшөөрөл олгож мэдээллйн санд бүртгэсэн.	Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 40-өөс доошгүй аж ахуйн нэгжид ус ашиглах, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл олгож, мэдээллийн санд бүртгэнэ.	2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар Нийслэлийн байгаль орчны газраас 6 аж ахуйн нэгж байгууллагын “Ус ашиглах дүгнэлт” ирүүлснээс 3 аж ахуйн нэгжид ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн. Үлдсэн 3 аж ахуйн нэгжийн хувьд ус ашиглах зөвшөөрлийн захирамж болон гэрээний төсөл боловсруулагдсан бөгөөд хяналтын шатандаа байна. Туул голын сав газрын захиргаанаас 9 аж ахуйн нэгж байгууллагын “Хаягдал усны дүгнэлт” ирүүлснээс 2 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, мэдээллийн санд бүртгэсэн. Үлдсэн 7 аж ахуйн нэгжийн хувьд	80%

						хаягдал ус хаях зөвшөөрлийн захирамжийн төсөл боловсруулагдсан бөгөөд арьс ширний үйлдвэрүүд байгаа учир хяналтын шатандаа байна.	
53	4.10.1 Нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслэн усны нөөц ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулж, усны мэдээллийн санд бүртгэнэ.	-	Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллага, тоо	Дүгнэлтийг үндэслэн 7 байгууллагад ус ашиглагчид зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан.	Дүгнэлтийг үндэслэн 20-оос доошгүй ус ашиглагчид зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан байна.	2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар Нийслэлийн байгаль орчны газраас 6 аж ахуйн нэгж байгууллагын “Ус ашиглах дүгнэлт” ирүүлснээс 3 аж ахуйн нэгжид ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн. Үлдсэн 3 аж ахуйн нэгжийн хувьд ус ашиглах зөвшөөрлийн захирамж болон гэрээний төсөл боловсруулагдсан бөгөөд хяналтын шатандаа байна.	70%
54	4.10.2 Туул голын сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана.	-	Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллага, тоо	6	Дүгнэлтийг үндэслэн 20-оос доошгүй ус ашиглагчид хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон байна.	2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Туул голын сав газрын захиргаанаас 9 аж ахуйн нэгж байгууллагын “Хаягдал усны дүгнэлт” ирүүлснээс 2 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, мэдээллийн санд бүртгэсэн. Үлдсэн 7 аж ахуйн нэгжийн хувьд хаягдал ус хаях зөвшөөрлийн захирамжийн төсөл боловсруулагдсан бөгөөд хяналтын шатандаа байна.	90%
Зорилт 4.11 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 5.1.6/		-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	6 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Холбогдох шатны байгууллагуудтай хамтарч түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 6-аас доошгүй удаагийн хяналт шалгалт зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа 21 аж ахуй нэгжээс Туул голын хамгаалалтын бүсэд Хүрээлэн буй орчны газар, Нийслэлийн байгаль орчны газрын хамтарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийн 3 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалж 18 нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 8 удаа хяналт шалгалтыг хийж ажилласан. Нийт 3 байршлын 4.8 га талбайд нөхөн сэргээлт хийлгэсэн.	100%

55	4.11.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	6 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Холбогдох шатны байгууллагуудтай хамтарч түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 6-аас доошгүй удаагийн хяналт шалгалт явуулна.	Дүүргийн хэмжээнд ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа 21 аж ахуй нэгжээс Туул голын хамгаалалтын бүсэд Хүрээлэн буй орчны газар, Нийслэлийн байгаль орчны газрын хамтарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийн 3 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалж 18 нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 8 удаа хяналт шалгалтыг хийж ажилласан. Нийт 3 байршлын 4.8 га талбайд нөхөн сэргээлт хийлгэсэн. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/125 дугаар захирамжаар 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын ачааны авто тээврийн хэрэгслийн бүх жинг “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011 стандартад заасны дагуу хязгаарлаж, тээвэрлэлт хийх хугацааг өглөөний 08:00 цагаас оройны 22:00 цаг хүртэл байхаар тогтоож, хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. Замын цагдаагийн хэлтэс “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011 стандартыг мөрдүүлэх зорилгоор том оврын ачааны тээврийн хэрэгслийн даацыг шалгах явуулын хэмжих төхөөрөмж /пүү/ ажиллуулж эхэлсэн бөгөөд даац хэтрүүлсэн 90	100%

						тээврийн хэрэгсэлд арга хэмжээ тооцож ажилласан.	
Зорилт 4.12 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна. /ДЗДҮАХ 2.1.4/		-	Хамрагдсан тамирчдын тоо, Хэрэгжилтийн хувь	Спортын 8 төрөлд 775 тамирчин оролцуулсан.	Спортын 8 төрөлд 2000-аас доошгүй тамирчин оролцуулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрийн 5.4.1-т “Залуучуудын биеийн тамир, спортоор хичээллэх, дугуйлан клубуудын үйл ажиллагааг дэмжиж, дүүргийн Засаг даргын дэргэдэх залуучуудын шигшээ багийг байгуулна” заалтыг тусган батлуулсан.	70%
56	4.12.1 Дүүргийн хэмжээнд өсвөр үе, хүүхэд залуучуудыг дугуйлан секцэд хамруулж улс, нийслэл болон дүүргийн хэмжээний спортын тэмцээнд оролцуулна.	-	Хамрагдсан тамирчдын тоо, Хэрэгжилтийн хувь	Спортын 10 төрөлд 236 хүүхэд хамрагдаж, олон улс болон улсын тэмцээнээс алт-10, мөнгө-21, хүрэл-35 нийт 66 медаль хүртсэн.	Спортын 8 төрөлд 200-аас доошгүй тамирчин оролцуулна.	-Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь спортын 10 төрлөөр 250 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл сургуулилтаа хангаж байна. Цахим сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж, өсвөрийн шигшээ багийн 54 удаагийн цахим хичээлийг Нийслэлийн болон Хан-Уул дүүргийн спорт хорооны цахим хуудаснуудад байршуулан 20,050 хүнд хүргэсэн байна. -Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид жудо бөхийн Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 5 алт, 2 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр I-р байр, Софт теннисний тэмцээнд багийн дүнгээр II байранд шалгарч, амжилттай оролцсон.	70%
Зорилт 4.13 Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд		-	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо, Хэрэгжилтийн хувь	-	16 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Нийт эрүүл мэндийн байгууллагуудад 88 нэр төрлийн 728 тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл нийлүүлэгдэж дууссан.	100%

чанартай хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зорилгоор “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 2.2.8/							
	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулан батлуулж, хугацаанд нь тайлагнах.					Нийслэлийн Засаг даргын жилийн эцсийн байдлаар 28 захирамжийн 31 заалтын биелэлтийг нэгтгэн, баталгаажуулж monitoring.ulaanbaatar.mn програмаар тайлагнасан. /Биелэлтийн дундаж-96.7/ Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 13 тогтоолын биелэлтийг нэгтгэн, батлуулж Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 04/1529 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлтийн дундаж-96.8/ 2021 оны жилийн эцсийн байдлаар 7 тогтоол шийдвэрийн холбогдох 22 заалтуудыг хяналтад авч, биелэлтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг болон Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албадаас авч нэгтгэн, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 04/1730 дугаар албан бичгээр хүргүүлсэн./Биелэлтийн дундаж-91.3%/ Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хяналтад байгаа нийт 32 тогтоол шийдвэрийн холбогдох 84 заалтуудын биелэлтийг нэгтгэн, холбогдох албан тушаалтанд танилцуулж, батлуулсан. /Биелэлтийн дундаж- 93%/	
96	5.1.10 Нийслэл, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнах, дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай	-	Дүүргийн шуурхай зөвлөгөөн зохион байгуулсан тоо, үүрэг даалгаврын биелэлтийн хувь,	Үүрэг даалгавар 83%-тай хэрэгжсэн.	Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж, хугацаанд нь тайлагнасан байна.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 42 удаа цахимаар зохион байгуулагдан, 330 үүрэг даалгавар өгөгдөж, 88.9%-тай хэрэгжсэн. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2021 оны жилийн эцсийн байдлаар 23	100%

	зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулах		хугацаандаа тайлагнасан эсэх			удаа цахимаар зохион байгуулан, нийт 116 үүрэг даалгавар өгөгдөж, 89.4%-тай хэрэгжсэн	
97	5.1.11 Дүүрэгт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх	-	Хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо, үр дүн, тайлан	5 төрлийн бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн.	Бодлогын баримт бичгүүдэд хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 108 зорилтын 151 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бүлэг, 8 зорилт, 8 арга хэмжээ, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 5 бүлэг, 15 зорилт, 28 арга хэмжээний хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албад тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. /Хэрэгжилтийн дүн– 92.1%/	100%
98	5.1.12 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг тавих замаар үүрэг хариуцлагыг дээшлүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо, тайлагналт	Хяналт-шинжилгээ үнэлгээг 2 удаа зохион байгуулж, үр дүнг тайлагнасан.	2-оос доошгүй удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний 206 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан нийслэлийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/607 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-	100%

						шинжилгээ, үнэлгээ хийх 4 ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, 2021 оны 12 дугаар сарын 15-24-ний өдрүүдэд шалгалтын ажлыг зохион байгуулж, 25 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгч дүгнэсэн.	
99	5.1.13 Хороодын хэсгийн ахлагч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна.	5.0	Зохион байгуулсан эсэх, үр дүн	Зөвлөлдөх уулзалтад 187 хэсгийн ахлагчийг хамруулсан.	Арга хэмжээг зохион байгуулж, холбогдох албан тушаалтанд тайлагнасан байна.	Иргэдэд мэдээ, мэдээллийг түгээх, үйл ажиллагааг сурталчлан таниулах, судалгааг хэрхэн оновчтой, бодитой авах чиглэлээр 21 хорооны Хэсгийн ахлагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэсгийн ахлагчдыг уулзалтыг 2021 оны 11 дүгээр сард зохион байгууллаа. Уулзалтад дүүргийн Засаг дарга, Засаг даргын нэгдүгээр орлогч, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, тасгийн дарга, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагчид оролцлоо.	100%
100	5.1.14 Хороодын Засаг дарга, Зохион байгуулагч, Хөгжлийн нийгмийн ажилтан нарын ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулна.	12.0	Хамрагдсан хороодын тоо, албан хаагчдын тоо	Нийт 20 хорооны 67 албан хаагч хамрагдсан.	Албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Цар тахлын улмаас төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй	-
101	5.1.15 Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь тайлагнана.	-	Шуурхай зөвлөгөөн зохион байгуулсан тоо, үүрэг даалгаврын биелэлтийн хувь, хугацаандаа тайлагнасан эсэх	4 удаа зохион байгуулж, 20 үүрэг даалгавар өгөгдөн 90%-тай хэрэгжсэн.	Биелэлтийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж, хугацаанд нь тайлагнана.	Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 16 удаа зохион байгуулж, 172 үүрэг даалгавар өгөгдөн, 85 хувьтай хэрэгжсэн байна.	100%

102	5.1.16 Дүүргийн Засаг дарга, хороодын Засаг дарга нартай батламж гэрээг байгуулах арга хэмжээг зохион байгуулна.	-	Батламж гэрээг байгуулсан эсэх	21 хорооны Засаг даргатай батламж гэрээ байгуулсан.	Батламж гэрээний хэрэгжилтийг хангасан байна.	Дүүргийн Засаг дарга, хороодын Засаг дарга нартай батламж гэрээг байгуулан ажиллаж байна.	100%
103	5.1.17 Иргэдийн эрэлт, хүсэлт, өргөдөл, гомдлыг ERP "Өргөдөл гомдлын нэгдсэн систем" болон бусад арга хэрэгслээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хариуг иргэнд шуурхай өгч ажиллана.	-	Дүүргийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн индекс, шийдвэрлэлтийн дундаж хоногоор	3233 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 08 хоног, 22 цаг, 08 минутад шийдвэрлэсэн.	Нийслэлийн түвшингөөс доош хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтад гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх зорилт тавьж ажилласан. 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2920 өргөдөл ирсэн бөгөөд үүнээс хуулийн хугацаанд 2819, хугацаа хэтрүүлэн 48 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2020 оны тайлант хугацаанд 08 хоног 22 цаг 08 минут байсныг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 08 хоног 01 цаг 14 минут болгон бууруулсан үзүүлэлттэй байна. Засаг даргын Тамгын газарт 878 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 854 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 19 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 07 хоног, 16 цаг, 05 минут байна.	100%
104	5.1.18 Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион	-	Уулзалтад хамрагдсан иргэдийн тоо	Нийт 103 иргэний хүсэлтийг	Тухай бүр иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулж, санал хүсэлтийг	Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар батлагдсан “Дүүргийн удирдах албан тушаалтнуудын	100%

	байгуулж, тэмдэглэл хөтлөн иргэдээс гарсан санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.			шийдвэрлэж, хариу өгсөн.	шийдвэрлэж ажиллана.	иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу уулзалтыг 7 хоног бүрийн Мягмар гарагт, шаардлагатай тохиолдолд Пүрэв гарагт батлагдсан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч биечлэн уулзан санал, хүсэлтийг сонсон шийдвэрлэж, хариу өгсөн. Уулзалтаар иргэдээс тавьж буй санал, хүсэлтийг газар дээр шийдвэрлэж, хариу өгөх зорилгоор чиг үүргийн хамааралтай хэлтэс, албадын удирдлагуудыг оролцуулж хэвшсэн. Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар А/108 тоот Нийслэлийн Засаг даргын захирамжийн 1.3-т заасны дагуу олон нийтийн арга хэмжээ буюу хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулахыг түр зогсоосон байсан тул 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс хойш 3 удаагийн уулзалт зохион байгуулж, 26 иргэнтэй уулзаж, гарсан санал, хүсэлтийг холбогдох хэлтэс, албадын даргад газар дээр нь үүрэг чиглэл өгч, шийдвэрлэлтийн тайлан гаргаж ажилласан.	
105	5.1.19 Иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох ажлыг зохион байгуулна.	-	Буцалтгүй тусламжид хамрагдсан иргэдийн тоо	145 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	Журмын дагуу иргэдэд буцалтгүй тусламж олгосон байна.	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай журам”-ыг мөрдөн, ажилласан. Журамд заасны дагуу хороодын Нийгмийн ажилтнаар мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр очин судалгаа	100%

						хийлгэж, нөхцөл байдлын үнэлгээг батлагдсан маягтын дагуу хийлгэсний үндсэн дээр 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дүүргийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар нийт 92 иргэнд 33,100,000 /гучин гурван сая нэг зуун мянган/ төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.	
106	5.1.20 Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянаж, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцох.	-	Захиргаан ы акт хуульд нийцсэн Хэрэгжилтийн хувь	94,7%	Захиргааны акт хуульд нийцэн 95%-иас дээш хэрэгжсэн байна.	Засаг даргын 673 захирамж, ЗДТГ-ын даргын 526 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Засаг даргын 514 захирамжийн үүрэг болгосон 668 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн биелэлтийг тооцон ажиллахад 95.7% буюу хангалттай хэрэгжсэн байна.	100%
107	5.1.21 Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах гэрээний үндэслэлийг хянан бүртгэлжүүлэх.	-	Бүртгэлжүүлс эн гэрээний тоо	437 гэрээг хянаж бүртгэлжүүлс эн	Гэрээ хуульд нийцсэн 100% бүртгэлжүүлсэн байна.	Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан **471** гэрээний эрх зүйн үндэслэлийн хянан бүртгэлжүүлсэн.	100%
108	5.1.22 Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, маргаан, нэхэмжлэлтэй холбогдуулан итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын	-	Шүүхэд төлөөлсөн үйл ажиллагааны хувь	24 хэрэг маргаанд оролцсон.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 100% төлөөлөн оролцсон байх	Захиргааны хэргийн шүүхэд 15, иргэний хэргийн шүүхэд 2, цагдаагийн байгууллагад 2 нийт 19 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцсон. Үүнээс: Анхан шатны шүүхийн 13, давж заалдах шатны шүүхийн 6, дээд шатны шүүхийн 5 нийт 24 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож: Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж гэрээ байгуулахыг даалгасан 2,	100%

	байгууллагатай харилцана.					иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 8, оролцогчид эвлэрч 2 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	
109	5.1.23 Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын хамтын гэрээг хянан бүртгэлжүүлэх.	-	Хуульд нийцүүлэн хянан бүртгэсэн гэрээний тоо	35 гэрээг хянан бүртгэлжүүлсэн.	Хамтын гэрээ хуульд нийцсэн бүртгэлд орсон байх	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 18 хамтын гэрээг хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хянан бүртгэлжүүлсэн.	100%
110	5.1.24 Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах, эрх зүйн сургалтыг иргэд, албан хаагчдад зохион байгуулах	3.0	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо	Цар тахлын улмаас хойшлогдсон.	6 сургалт зохион байгуулж, 350 иргэн, албан хаагч хамруулах	Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг тайлбарлах эрх зүйн сургалтыг иргэд, албан хаагч, сурагчдад зохион байгуулах ажлын хүрээнд жилийн эцсийн байдлаар 14 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1622 иргэн, албан хаагчдыг хамруулсан. Үүнээс:Хууль тогтоомжийг сурталчлах 7 сургалт зохион байгуулж 363 албан хаагч, 497 иргэн, 182 сурагчид хамрагдсан. Захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг тайлбарлах 7 сургалтыг зохион байгуулж 110 албан хаагч, 70 иргэн, 400 сурагчид хамрагдсан.	100%
111	5.1.25 Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	Хангалттай түвшинд хэрэгжсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс ХУД холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргахад 96.3 хувьтай хэрэгжсэн. Хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн Засаг	100%

						даргын Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/1757 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлсэн.	
112	5.1.26 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэгтэй хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, улирал тутам тайлагнаж ажиллана.	ҮА-ны зардлаар	Хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх	-	Тайланг нэгтгэн НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс Хан-Уул дүүрэг хариуцан болон хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/1757 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Хэрэгжилт 92.1%	100%
113	5.1.27 Нийслэлийн ИТХ түүний Тэргүүлэгчдээр батлагдсан хөтөлбөрүүд болон санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулан, тайлагнах ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	25% /жил бүр хангалттай түвшинд хэрэгжсэн байна./	Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад хөтөлбөрийн биелэлтийг ирүүлэх тухай Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021.11.25-ны өдрийн 06/1579 дүгээр албан бичгийг хүргүүлэн, тайланг авч, нэгтгэж байна. 2022 оны 01 дүгээр сард НЗДТГ-т хүргүүлнэ.	80%
114	5.1.28 Нийслэлийн дэд хөтөлбөр болон	ҮА-ны зардлаар	Хэрэгжилтийг хугацаанд нь	-	Тайланг нэгтгэн НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад хөтөлбөрийн биелэлтийг ирүүлэх тухай Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын	80%

	санамж бичиг, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулж, холбогдох хэлтэс албадаас тайланг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ.		хүргүүлсэн эсэх			газрын даргын 2021.11.25-ны өдрийн 06/1579 дүгээр албан бичгийг хүргүүлэн, тайланг авч, нэгтгэж байна. 2022 оны 01 дүгээр сард НЗДТГ-т хүргүүлнэ.	
115	5.1.29 Засаг даргаас бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дүүрэг хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэх, хяналт тавих, шаардлагатай бүх төрлийн мэдээллийг боловсруулан дүгнэлт, санал бэлтгэх ажлыг зохион байгуулж Засаг даргыг мэдээллээр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	25% /Жил бүр хангалттай үнэлэгдсэн байна./	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс Хан-Уул дүүрэг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргахад 96.3 хувьтай хэрэгжсэн бөгөөд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/1757 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар батлагдсан “Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс Хан-Уул дүүрэг хариуцан болон хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч, нэгтгэхэд 92.1 хувьтай хэрэгжсэн бөгөөд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06/1757 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	100%

116	5.1.30 Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулж, хэрэгжилт үр дүнг тайлагнана.	ҮА-ны зардлаар	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хувь	-	90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулан Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөр нь 5 бүлэг, 23 дэд бүлэг, 102 арга хэмжээтэй, хөтөлбөрийн хүрээнд 9 дэд хөтөлбөр хэрэгжихээр батлагдсан.Тус хөтөлбөрийн 2021 оны жилийн эцсийн биелэлтийг Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадаас авч, нэгтгэн боловсруулж, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, дүгнүүлсэн. Хэрэгжилт 90.4%	100%
117	5.1.31 Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	Гэрээ байгуулж дүгнэсэн байна.	Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай 2021.01.08-нд байгуулсан. Гэрээний биелэлтийг 2021.12.08-ны дотор авахаар холбогдох хэлтэс, албадад албан бичиг хүргүүлж, биелэлтийг хүлээн авсан. Биелэлтийг дүгнэх ажлын хэсэг байгуулагдаж байна. 2022 оны 1 дүгээр улиралд биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулна.	80%
118	5.1.32 Цахим баримт бичгийг хүлээн авах, шуурхай хянан шийдвэрлэх, цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх	-	Баримт бичгийн шийдвэрлэлтийн байдал, хувь	2020 онд нийт 2363 бичиг боловсруулсан	Баримт бичгийн шийдвэрлэлт зөрчилгүй, шуурхай шийдвэрлэсэн байна.	2020 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүргийн хэмжээнд 35982 бичгийг хүлээн авч, шийдвэрлэлтийн хувь 97,61% -тай байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 36345 бичгийг хүлээн авч, шийдвэрлэлтийн хувь 98,67% хувь болж өссөн бөгөөд	100%

	бодлого стандарт журмыг хэрэгжүүлж ажиллана.					20120 албан бичгийг төлөвлөн явуулсан байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 100 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 17 мэдээг бэлтгэн танилцуулсан байна. Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, сар тутмын 12, улирал тутмын 4 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн. Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нийт 5789 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2020 оны жилийн эцэст 4534 бичиг хүлээн авсан буюу энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 1255-аар өссөн. Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2020 оны жилийн эцсийн байдлаар 92,33% байсан бол 2021 оны жилийн эцэст 93,72% байна. Хариутай бичгийн тоо 2020 оны жилийн эцэст 358 байсан бол 2021 оны жилийн эцэст 344 буюу 14 хариутай албан бичгээр буурсан бөгөөд хаалтын хувь нь 2020 оны жилийн эцэст 93,89%, харин 2021 оны жилийн эцсийн байдлаар 94,41% байна. Зөрчлийн тоо 2020 оны жилийн эцэст 353 байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар жилд 381 буюу 28-аар өссөн байна. Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичгийн тоо 2020 оны жилийн эцсийн	

						байдлаар 18748 байсан бол 2021 оны жилийн эцэст 20120 буюу явуулсан албан бичгийн тоо 1372-оор өссөн. Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан албан бичгийн тоо 2020 оны жилийн эцсийн байдлаар 2170 байсан бол 2021 оны жилийн эцэст 2384 буюу явуулсан албан бичгийн тоо 214-өөр өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт өссөн дүнгээр 29173 албан албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 28941 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулж, 211 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй гэж үзэн цуцалсан	
119	5.1.33 Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулах MNS5140:2021 стандартыг мөрдөн ажиллана.	-	Стандартыг мөрдүүлж ажилласан эсэх	MNS5140:2011 стандартыг мөрдөн ажилласан.	Баримт бичгүүд стандартын дагуу боловсруулагдсан байна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын А захирамж 2021 оны байдлаар 1803, ЗДТГ-ын даргын тушаал 1046 нийт 2849 захирамжлалын бланк хэвлэгдсэн байна. Нийт захирамжлалын болон баримт бичиг болох зохион байгуулалт, мэдээлэл, лавлагааны баримт бичиг 2669 албан бичгийн боловсруулалтад Монгол улсын MNS 5140:2021 стандартыг хэрэгжүүлж ажилласан.	100%
120	5.1.34 Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлэх, албан хэрэг хөтлөгдөх хугацаа дуусмагц, зохих зааврын дагуу цэгцэлж, бүрэн бүрдэлтэйгээр баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу	-	Стандартын дагуу архивын нэгж үүсгэсэн эсэх, хүлээлгэн өгсөн баримтын тоо	580 баримтыг архивласан.	Баримт бичгийг стандартын дагуу архивлаж нөхөн бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт / Байгууллага дээр байнга хадгалах -4 □ Байнга хадгалах - 100 хн □ 70 жил хадгалах - 17 хн □ Түр хадгалах-467 хн/ 584 баримтыг хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийгдсэн.	100%

	байгууллагын архивт шилжүүлнэ.						
121	5.1.35 ЗДТГ-ын өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хагас болон бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ хийж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн тоо, хувь	2 удаа өмчийн тооллого зохион байгуулсан.	100%	ЗДТГ-ын өмчид байгаа хөрөнгийн ашиглалтад хагас болон бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ хийж, ашиглалтын хугацаа дууссан актлах тавилга эд хогшил 149 нэр төрлийн 40,818,054, машин тоног төхөөрөмжийн 190 нэр төрлийн 385,095,299, програм хангамжийн 13 нэр төрлийн 82,438,360, барилга байгууламж 85 нэр төрлийн 306,449,219 сая, нийт 814,800,932 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулан Нийслэлийн ӨАУГ-ын даргын тушаал шийдвэр гаргуулан акталсан. Мөн дүүргийн ЗДТГ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/74 дугаар тушаалаар 49 нэр төрлийн нийт 50,700,500 сая төгрөгийн эргэлийн бус хөрөнгийг акталсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 856 нэр төрлийн 995,469,422 төгрөгийн эд хөрөнгө худалдан авсан. Мөн ЗДТГ-ын 5 автомашиныг актлах шийдвэр гаргуулан акталсан.	100%
122	5.1.36 Аж, ахуйн нэгж байгууллага болон иргэдийн шагналын материалыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж, дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	-	Хамруулсан хүний тоо	356 иргэнд шагнал гардуулсан.	100%	Төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан 844 иргэнийг төрийн дээд одон медалиар, 3 аж ахуйн, нэгж байгууллагыг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хянан шалгаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 10, 18, 33 35, 36, 46 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж Нийслэлийн Засаг даргын	100%

						Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 17 дугаар тогтоолоор “Хан-Уул Хангарди медаль”, “Хүндэт тэмдэг”, “Манлайлагч сурагч”, “Манлайлагч залуу”, “Бүтээлч байгууллага” зэрэг нийт 5 төрлийн шагналын төрөлтэй болсон. Үүнээс Хан-Уул Хангарди медаль болон Хүндэт тэмдгийн загварыг шинэчлэн боловсруулан хийлгэж одоогийн байдлаар Хүндэт тэмдгээр 101 иргэн аж ахуйн нэгж байгууллагын ажилтныг шагнаж урамшуулаад байна. Алдарт эхийн 1, 2 дугаар одон авах болзол хангасан 555 эхийн 22 боть архивын баримтыг НЗДТГ-т хүргүүлсэн. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 14, 94 дүгээр зарлигаар төрийн дээд одон медалиар шагнагдсан 359 иргэний шагналыг гардуулах ёслолын үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан.	
123	5.1.37 Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулж, шийдвэрийн биелэлтийг гаргах.	-	Зохион байгуулсан хурлын тоо	10 удаагийн хурал зохион байгуулж 54 асуудлыг хэлэлцсэн.	100%	Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу 42 удаа зохион байгуулж, 205 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Тус хурлаас 179 үүрэг даалгавар өгөгдөж хэрэгжилт 87 хувьтай байна.	100%
124	5.1.38 Гадаадын зочид төлөөлөгчидтэй холбоо тогтоож, хамтын ажиллагааны хүрээнд санал хүргүүлж, хоёр талын хамтын ажиллагааны уулзалт зохион байгуулна.	-	Санал хүргүүлж, уулзалт зохион байгуулсан эсэх	Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуанжин дүүрэгтэй холбоо тогтоосон байна.		Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Гуанжин дүүрэг, Хаман сум, Турк Улсын Болгар хот, Тайланд зэрэг улсуудтай хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр шинээр холбоо тогтоох албан хүсэлтийг уламжилж, санал хүргүүлсэн.Гадаад томилолтыг 4 удаа зохион байгуулж, албан уулзалтын тайлан мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан.	100%
125	5.1.39 Гадаад, дотоодын байгууллагуудтай	-	Гэрээ санамж бичиг байгуулсан	-	2-оос доошгүй байгууллагатай	Дүүргийн ЗДТГ, Юнител ХХК-ийн хоорондын хамтын ажиллагааны	50%

	гэрээ, санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулна.		эсэх, гүйцэтгэлийн тоо		гэрээ, санамж бичиг байгуулна.	санамж бичиг 2021 оны 02 дугаар сарын 02 өдөр байгуулсан. Тус гэрээнд: Ковид-19 цар тахлын хөл хорио тогтоосон энэ үед нийт дүүргийн сурагчдад зориулж үнэ төлбөргүй 10,000 ширхэг дататай дугаараар хангах, сурагчдад хичээлийн хоцрогдол үүсгэхгүй байлгахын тулд шаардагдах вэб сайтруу /www.econtent.edu.mn/ хязгааргүй, үнэгүй холбогдоход зориулж шийдэл гаргана.“Юнител” ХХК, Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэстэй хамтран дүүргийн нийт багш, албан хаагчдын мэдлэгийг чадавхжуулах, багаар ажиллах чадварыг сайжруулахын тулд цоо шинэ Дижитал “ECO-QUIZ” асуулт хариултын уралдаан, тэмцээнийг 100 хувь санхүүжүүлэн зохион байгуулах, дүүргийн нийт багш, сурагчдад цаг алдалгүй мэдээ мэдээллээр хангах, масс мессэж бичих програмыг үнэ төлбөргүй болгох зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.	
126	5.1.40 Гадаадын улс орнуудад туршлага солилцож, сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг гаргана.	-	Судалгаанд хамрагдсан албан хаагчдын тоо	2020 онд Япон улс, Швед улс, Турк улсуудад нийт 13 албан хаагчийг гадаад арга хэмжээнд хамруулсан.	Албан хаагчдын судалгааг гаргасан байна.	Гадаадын улс оронтой хамтран ажиллах зорилтын хүрээнд гадны улс орноос туршлага судлуулах 100 албан хаагчаас судалгаа авч, 2021 онд Солонгос улс -2, Тайланд улс -1, Турк улс -1 удаа тус тус албан томилолтын ажлыг зохион байгуулан нийт 20 албан хаагчийг туршлага судлуулах сургалтад хамруулаа.	100%
127	5.1.41 Дүүргийн иргэдийг үнэн зөв ил тод шуурхай мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.	-	Мэдээний тоо, хамруулсан хүний тоо	1512 мэдээ мэдээллийг дүүргийн цахим оруулсан.	100%	Дүүргийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэдэд үнэн зөв ил тод ,түргэн шуурхай хүргэх зорилгоор ЗДТГ-ын албан ёсны цахим www.khanuul.mn вэб сайт, “Хан-Уул Эко дүүрэг”, “Нээлттэй Хан-Уул”, “Хан-уул дүүргийн Шуурхай штаб” зэрэг 4	100%

						чиглэлийн цахим хуудаснуудаар нийт 2975 мэдээ, мэдээлэл, зөвлөмж, видео, контентыг бэлтгэн хүргэсэн. Дээрх цахим хуудаснуудад 2021 онд 754103 иргэн хандаж, мэдээлэл авсан байна.	
128	5.1.42 Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах.	-	Тамхины тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн тоо	124 иргэн, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон.	Тамхины зөвшөөрлийн тоог бууруулна.	Тамхи худалдах тусгай зөвшөөрөл хүссэн 187 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 6 удаагийн хурлыг зохион байгуулж хэлэлцүүлэн, 112 иргэн, аж ахуйн нэгж буюу нийт хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн 59.8%-д нь тусгай зөвшөөрөл олгосон. Үүнд: • Шинэ-53 • Сунгалт-48 • Нэр шилжүүлэх-11 Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран хяналт шалгалт хийж, албадлагын арга хэмжээ авч, хураагдсан 39 төрлийн 250 хайрцаг тамхийг үнэлүүлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан.	100%
129	5.1.43 Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжүүдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж, худалдаа үйлчилгээ гэрээ байгуулж, батламж олгоно.	-	Гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	1100 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж батламж олгосон.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.	Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн хурлыг 30 удаа 62 асуудлаар хуралдаж тухайлсан шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Үүнд : • Худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээг 1271 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. • Тамхины тусгай зөвшөөрөл 112 аж ахуй нэгжид олгосон. • Тамхи худалдан борлуулах 1 тусгай зөвшөөрлийг цуцалсан. • Нийтийн эзэмшлийн зам талбайд ТҮЦ-ийн зөвшөөрөл хүссэн 10 иргэнд шийдвэр хүргүүлсэн.	100%

						Зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэг, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийг нүүлгэх чиглэлээр газар зохион байгуулалтын алба, Мэргэжлийн хяналтын хэлтсээс албан мэдэгдэл, шаардлагыг хүргүүлсэн.	
130	5.1.44 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, холбогдох хэлтэс албадаас тайланг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлнэ.	ҮА-ны зардлаар	Тайланг нэгтгэн хугацаанд нь хүргүүлсэн эсэх	-	Тайланг нэгтгэн хугацаанд нь хүргүүлнэ.	Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад хөтөлбөрийн биелэлтийг ирүүлэх тухай Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021.11.25-ны өдрийн 06/1579 дүгээр албан бичгийг хүргүүлэн, тайланг авч, нэгтгэж байна. 2022 оны 01 дүгээр сард НЗДТГ-т хүргүүлнэ.	50%
Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 44 арга хэмжээ 96.1 хувьтай хэрэгжсэн.							
ЗУРГАА. БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 6.1 Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ.							
131	6.1.1 “ЭРХМИЙН ДЭЭД МОНГОЛ ЭР ХҮН” сэдэвт эсээ бичлэгийн цахим уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулна.	-	Эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан эсэх, хамрагдсан сурагчдын тоо	-	Дүүргийн Ерөнхий боловсролын 18 сургуулийн 1562 гаруй сурагчид хамрагдана	Зэвсэгт хүчний Жанжин штабаас орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан “Монгол Улсын Зэвсэгт хүчин-100” сэдэвт гар зургийн уралдааны удирдамжийг салбар хороо болон Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулан дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад цахимаар хүргүүлж 18 сургуулийн 52 суралцагч бүтээлээ ирүүлснийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлсэн. Хоёрдугаар шатны шалгаруулалтад тус дүүргээс Ерөнхий боловсролын дунд сургуулийн бага ангийн /6-10 нас/-ны ангиллын тусгай байрт “Монгол билэг оюун” сургуулийн 2г ангийн суралцагч Э.Дагва-Очир, дунд ангийн /11-14 нас/-ны ангилалд “Хүмүүн” дунд сургуулийн 7 дугаар ангийн суралцагч Э.Хонгорзул нар шалгарч Зэвсэгт хүчний Жанжин	90%

						штабын даргын дурсамж, үнэ бүхий зүйлээр шагнагдсан.	
132	6.1.2 Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид болон Боловсролын хэлтэстэй хамтран зохион байгуулах	-	цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээн зохион байгуулсан эсэх, хамрагдсан сурагчдын тоо	-	Ерөнхий боловсролын 18 сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан байна.	“Ковид-19” цар тахлын улмаас цуцлагдсан.	-
133	6.1.3 Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран “Монгол цэргийн бахархал” өдөрлөгийн арга хэмжээг дүүргийн иргэдтэй зохион байгуулах	-	“Монгол цэргийн бахархал” өдөрлөг зохион байгуулсан эсэх, оролцсон иргэдийн тоо	-	Өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчилж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэсэн байна.	“Монгол цэргийн бахархал” арга хэмжээ “Ковид-19” цар тахлын улмаас цуцлагдсан боловч дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа алба хаагчдад дүүргийн Засаг даргын мэндчилгээ болон коронавируст цар тархалтаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2000 ширхэг амны хаалт, 800 ширхэг амин дэм вакус, 200 ширхэг гар ариутгагч, ариутгалын иж бүрэн хэрэгслийг Цэргийн штабын дарга хурандаа Г.Жаргалсайхан хугацаат цэргийн алба хаагчдад гардуулсан. - Зэвсэгт хүчин 100 жилийн ойг тохиолдуулан “Гурван үеийн уулзалт” нэвтрүүлгийг “NTV” телевизтэй хамтран зохион байгуулсан. Тус нэвтрүүлэгт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Д.Дондов, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн дивизоны захирагч, дэд хурандаа Д.Төмөрхуяг,	70%

						мөн ангийн салааны захирагчийн орлогч, түрүүч П.Дөлгөөнсүх нарыг оролцуулсан.Цэргийн штабаас чөлөөнд гарсан бэлтгэл хурандаа А.Баттулга, Ч.Батхүрэл, бэлтгэл дэд хурандаа Д.Мөнхбат, бэлтгэл ахмад Б.Ганчимэг, Зэвсэгт хүчний 120 дугаар ангиас чөлөөнд гарсан бэлтгэл хурандаа Д.Дондов нарт дүүргийн Засаг даргын дурсамж, гарын бэлгийг мэдээллийн аюулгүй байдлын офицер, хошууч Н.Цэцэгбал, төлөвлөлт, сургалтын офицер, ахмад Э.Бат-Эрдэнэ нар 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр хүргэж, хүндэтгэл үзүүлсэн.	
134	6.1.4 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2021 оны ээлжит цэрэг халалт, татлагын үйл ажиллагааг зохион байгуулах	-	Цэрэг татлагын арга хэмжээг зохион байгуулсан эсэх, тоон даалгаврыг биелүүлсэн эсэх.	Тоон даалгаврыг бүрэн биелүүлсэн.	Зэвсэгт хүчин , Хилийн цэрэг, Дотоодын цэргийн нөхөн хангах тоон даалгаврыг бүрэн биелүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/721 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын А/500 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/96 дугаар тушаалаар цэрэг татлагын ажлын төлөвлөгөө, ажиллах 140 албан тушаалтныг томилон баталгаажуулж хэрэгжилтийг хангасан. Зэвсэгт Хүчин, Хилийн ба дотоодын цэрэгт цэргийн жинхэнэ алба хаалгахаар нийслэлийн Цэрэг татлагын товчооноос өгсөн тоон даалгавраар Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангах цэрэг татлагын тоон даалгаврыг 100 хувь биелүүлж, цэргийн жинхэнэ албанд татагдагчдын 6 иргэн буюу 3,07 хувь нь дээд боловсролтой, 22 иргэн буюу 11,2 хувь нь тусгай дунд боловсролтой, 160 иргэн буюу 82,05 хувь нь бүрэн дунд боловсролтой, 7 иргэн буюу 3,1 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байсан.	100%
135	6.1.5 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн	-	“Оюутан-цэрэг”-т цэргийн	-	НЗДТГ-аас ирүүлсэн оюутан цэргийн тоон	“Ковид-19” цар тахлын улмаас цуцлагдсан.	-

	дагуу 2021 оны “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах		мэргэжил олгох сургалтыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан оюутны тоо		даалгаврыг биелүүлсэн байна.		
136	6.1.6 Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний ойн баярын үйл ажиллагаа, генерал цолтонд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна.	-	Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулсан эсэх, хүндэтгэл үзүүлсэн генерал цолцонгуудын тоо	100 хувьтай хэрэгжсэн.	ХУД-ийн нутаг дэвсгэрт оршин суудаг 15 генерал цолцонгуудад хүндэтгэл үзүүлнэ.	Монгол улсад Генерал цол бий болсны 77 жилийн ойг тохиолдуулан тус дүүрэгт оршин суудаг 15 генерал цолтнуудад дүүргийн Засаг даргын мэндчилгээг Khan-Uul.mn веб сайт, Фейсбүүк хуудас хуудсаар дамжуулан хүргэсэн.	100%
137	6.1.7 Дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын 18-50 насны цэргийн үүрэгтний Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үзлэг шалгалт явуулна.	-	Үзлэг явуулсан аж ахуй нэгж байгууллагын тоо	100 хувьтай 12 ААНБ-ыг шалгасан.	Батлагдсан аж ахуй нэгж байгууллагын бүрэн шалгаж цэргийн үүрэгтний зөрчлийг арилгасан байна.	Дүүргийн Засаг даргын 2021 оны А/34 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн 2 буюу “Хан-Уул дүүргийн татварын хэлтэс” “Улаанбаатар Цахилгаан дамжуулах сүлжээ”, хувийн хэвшлийн 4 “Бетон арматур ХХК”, “МСМ групп”, “Улаанбаатар баруун түгээх төв”, “Номин холдинг ХХК” зэрэг нийт 6 байгууллага, аж ахуйн нэгжийн 397 ажилтан, албан хаагчдад Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулахаас 375 цэргийн үүрэгтнийг тус шалгалтад хамруулж, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол шаардлага хангасан 31 иргэнд хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх	90%

						албаны мөнгөн төлбөр тогтоосноос 18 иргэнд 6,615,422 сая төгрөгийн мөнгөн төлбөрийг оногдуулж Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн. Цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, арга зүйн зөвлөгөө өгсөн.	
138	6.1.8 Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу дүүргийн албан тушаалтны цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах	-	цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан албан тушаалтны тоо	4 удаа сургалтыг зохион байгуулсан.	Цэргийн штабын 2021 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан сургалтыг бүрэн зохион байгуулна.	Цэргийн штабын 2021 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2021 оны 2 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Стратегийн команд штабын сургууль зохион байгуулагдаж, Цэргийн штаб хээрийн бэлэн байдлыг дэлгэн, Орон нутгийн хамгаалалтын удирдах 12 хүний бүрэлдэхүүнтэй сургалтыг зохион байгуулсан. Цэргийн штабын хээрийн бэлэн байдалтай Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орлогч, хурандаа Л.Мөнхбат газар дээр нь танилцаж, үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдлын техник хэрэгсэлтэй танилцсан.	100%
139	6.1.9 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах	-	Цэргийн бүртгэлийн хамралтын хувь	94,4 хувьтай хэрэгжсэн.	Цаасан суурьтайгаар 90 хүртэл хувьтай хамруулсан байна.	2021 оны цэргийн бүртгэлийг 2021 оны 1 дүгээр сарын 13- 27-ны өдрүүдэд Засаг захиргааны үндсэн нэгж хороонд төвлөрүүлэн, хорооны Засаг дарга нар эрхлэн зохион байгуулсан. Засаг даргын Тамгын газрын дарга захиргааны удирдлагаар, Цэргийн штаб цэргийн мэргэжлийн удирдлагаар хуулийн дагуу ханган ажиллаж, хорооны цэргийн бүртгэлийн хэсгийн ажиллах цагийн хуваарийг баталгаажуулан ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд явуулахаар зохион байгуулан, өдөр бүр	100%

						салбар, комиссын гишүүд хариуцсан хорооны цэргийн бүртгэлийн явц үр дүн, иргэний мэдээллийн баяжилт, шинээр бүртгэгдэж байгаа иргэдэд хөтлөгдөж байгаа маягтуудын хөтлөлтөд хяналт тогтоон ажилласан. Мэдээлэл, сурталчилгааны олон төрлийн хэлбэрийг ашиглан 2021 оны Цэргийн бүртгэлийг журмын дагуу цахимаар зохион байгуулж, 18-50 насны цэргийн үүрэгтний бүртгэлийг 91,2 хувьтай зохион байгуулсан.	
140	6.1.10 Дайчилгааны тухай хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүд цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулах.	-	Сургалтуудыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтний тоо	3 удаа сургалт зохион байгуулсан.	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, цэргийн дүйцүүлэх алба хаагчдад хууль эрх зүйн болон цэргийн хэргийн мэдлэг олгож, үүрэг гүйцэтгэх дадлага эзэмшүүлсэн байна.	Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтад хамрагдах 260 иргэнийг дайчилгааны мэдэгдэх хуудсаар дуудаж 80 иргэнтэй гэрээ байгуулж Зэвсэгт хүчний 303 дугаар ангитай хамтран 2021 оны 8 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулсан.	100%
141	6.1.11 Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын мэргэжил арга зүйн сургалтад оролцох, дотооддоо батлан хамгаалах хууль, тогтоомжоор сургалт зохион байгуулах.	-	мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулагдсан эсэх, сургалтын тоо	4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	2021 оныг **“**Төрийн батлан хамгаалах үйлчилгээ-Цахим шинэчлэлийн жил” болгосонтой холбогдуулан нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар дараах сургалтад хамрагдсан. Үүнд: -Монгол бичгийн 40 цагийн сургалт -Төрийн албан хаагчийн м%анлайлал - Албан хэрэг хөтлөлт -Мотобуудлагын батальоны байлдаан -Цэргийн алба хаагчийн албандаа хандах хандлага түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлс -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл	80%

						-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт 5 цагийн цахим багц сургалтад амжилттай хамрагдан шалгалт өгч сертификат хүлээн авсан.	
142	6.1.12 “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх” сэдэвт болзолт уралдааныг Өрхийн эрүүл мэндийн төвүүд, нарийн мэргэжлийн их эмч нарын дунд зохион байгуулах, үр дүнг тооцох.	-	болзолт уралдааныг зохион байгуулан дүгнэж, үр дүнг тооцсон эсэх	92 хувьтай хэрэгжсэн.	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал тодорхой хувиар дээшилсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх” болзолт уралдааны үр дүнг тооцон ажилласан.	90%
143	6.1.13 Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна.	-	Томилгоот бүрэлдэхүүний сургалт зохион байгуулагдсан эсэх, оролцсон албан тушаалтны тоо	100 хувьтай хэрэгжсэн	Томилгоот албан тушаалтнуудын үүрэг гүйцэтгэх мэдлэг дадлага дээшилсэн байна.	Цэргийн штабын 2021 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цугларах, Техник шилжүүлэх байрны томилгоот бүрэлдэхүүнийг тодотгож албан тушаалтнуудтай 2021 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтаар томилгоот бүрэлдэхүүнд дайчилгааны тухай хуулиар хүлээсэн үүрэг, эрх зүйн үндэслэл, Зарлан мэдээлэх дохиогоор ажиллах үед албан тушаалтнуудын үүрэг болон бусад асуудлаар Цэргийн штабын дайчилгааны офицер хошууч Н.Мөнгөнө мэдээлэл хийж харилцан ярилцаж томилгоот албан тушаалтнуудад онолын мэдлэг дадлагыг нэмэгдүүллээ.	100%

144	6.1.14 Хорооны Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл сургалтыг” зохион байгуулах	-	Сургалт зохион байгуулагдсан эсэх, ирцийн хувь	-	Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдсан байна.	Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайд Нийслэлийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний дагуу Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Тус сургалтаар 21 хорооны Засаг дарга нар 85.7 хувийн ирцтэй хамрагдсан.	85.7%
145	6.1.15 Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх	-	Мөнгөн төлбөрөөр орлуулан хаах иргэдийн тоо, төлсөн мөнгөн дүн	95 хувьтай хэрэгжсэн.	Батлагдсан нэрсийн жагсаалтын дагуу мөнгөн төлбөрийг барагдуулж,бүртгэл тооцоо хөтлөгдсөн байна.	Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 1994-1995 онд төрсөн 340 иргэнийг мэдэгдэх хуудсаар дуудан дүүргийн 21 хороонд хуваарь гарган 2021 оны 5 дугаар сарын 19-31-ний өдрүүдэд дүүргийн Спорт хорооны байранд мөнгөн төлбөр тогтоон Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 141 иргэнээр 116,337,774 төгрөг төвлөрүүлсэн.	100%
146	6.1.16 Цэргийн албаны тухай хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавина.	-	цэргийн дүйцүүлэх албанд элссэн иргэдийн тоо, үүрэг гүйцэтгэлтийн хувь	2020 онд 10 иргэн элсэж алба хааж байна.	НИХТ-ийн тогтоолоор батлагдсан тооны дээ хязгаарт багтаан дүйцүүлэх алба хаагчийг элсүүлж анхан, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулсан байна.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан тоон даалгаврын дагуу дүүргийн Засаг даргын 2021 оны А/246 дугаар захирамжаар 6 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэн гэрээ байгуулсан. 2021 онд элссэн цэргийн дүйцүүлэх алба хаагч нартай 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр цахимаар сургалтыг зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг биеэр 24 сар алба хааж хугацаа дуусган халагдсан 6 иргэнд Цэргийн	100%

						штабын дарга, талархал, мөнгөн урамшуулал, цэргийн үүрэгтний үнэмлэхийг гардуулсан.	
Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 16 арга хэмжээ 93.2 хувьтай хэрэгжсэн.							
НИЙТ 146 АРГА ХЭМЖЭЭ 93.1 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН.							

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА ..... Ж.АЛДАРЖАВХЛАН

ТАМГА 2021-12-24

(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ..... С.ЭНХБАЯР

ТАМГА 2021-12-24

(огноо)